# Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр

## Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар

## 2024 оны жилийн эцэс

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Суурь түвшин | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. НЭГ.КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| 1 | 1.1. Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ. | 1.1.1. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 81 | ОНТ 300.0 | 90 | Улирлын томуугийн дархлаажуулалтад аймгийн хэмжээнд 2-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, 65-аас дээш нас, архаг хууч өвчтэй ахмадууд, эрүүл мэндийн байгууллагын ажилчид нийт эрсдэлт бүлгийн 21350 хүн амыг хамруулахаас 18862 хүн амыг хамруулж хамрагдалт 88.3 хувьтай болсон байна. Жил бүр улирлын томуугийн дархлаажуулалт хийгдсэнээрээ 2022 онд амьсгалын замын халдварт өвчин 5258 бүртгэгдэж байсан бол 2024 онд 1380 болж 3,8 дахин буурсан байна. Зарцуулсан санхүүжилт 300.000.000 | 81.1% / 81.1% |
| 2 | | 1.1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний | 2021 - 2024 | 78 50 | УТХО 11511,2 Хандив тусламж 3405,2 | 90 60 | Халдварын дэгдэлтийн үеүдэд тохиолдол бүрийн тандалт судалгаагаар хавьтал нийт 81471 хүнийг хяналтад авч, түргэвчилсэн шинжилгээ болон баталгаажуулах шинжилгээнд хамруулж хавьтлын хяналтыг хийж ажилласан. 2022 оноос Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд коронавирусын халдварын | 100% / 100%Хүрсэн түвшинг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлэн байдлыг хангах. | | | | | тандалтыг нэгтэн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж үйл ажиллагааг тогтмолжуулсан. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоогоор 2024 оны 40 дэх 7 хоногийн байдлаар шинээр эмнэлэгт хэвтэгсдийн дунд эзлэж АЗЦХХ-ын шалтгаантай өвчтний хувь 15,3 хувиар, нийт эмнэлэгт хэвтэгсдийн дунд эзлэх АЗЦХХ-ын шалтгаантай өвчтний хувь 0,7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Томуу, Томуу төст өвчний тархалтын түвшин “Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээгээр “Идэвхжлийн түвшин”-д байна. 2021 онд гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалт 80.0 хувьтай байсан бол 2024 онд Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалт 91.2 хувьтай болж 11.5 хувиар өссөн байна. Зарцуулсан санхүүжилт 112.492.525.00 2021-2024 онуудад аймгийн эрүүл мэндийн салбарт 3.667.3 сая төгрөгний үнэ бүхий хамгаалах хувцас хэрэгсэл, урвалж, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг авч COVID-19 вирусын цар тахлын дэгдэлт, гамшгийн үеийн нөөцийн бэлэн байдлыг нэмэгдүүллээ. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах зорилгоор нийт давхардсан тоогоор 526 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, эм эмнэлгийн хэрэгсэлийн чиглэлээр | үүсвэрийг сая төгрөгөөр илэрхийлж системийн холбогдох талбарт тайлагнах. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтуудыг зохион байгуулж, эм эмнэлгийн хэрэгсэлийн бэлэн байдалд үнэлгээ хийлээ. "Гамшгийн үеийн сэтгэц-нийгмийн дэмжлэг үзүүлэх” говийн бүсийн бүсчилсэн танхимын сургалтад 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Осголт, хөлдөлтийн үед авах арга хэмжээ, Угаарын хийн хордлогын үеийн эмнэлзүй, авах арга хэмжээ цахим сургалтад 45 эмч, эмнэлгийн ажилтныг тус тус хамруулж мэдлэгийг дээшлүүллээ. Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 93 төрөл байна. 2024 онд гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 90.7 хувьтай болж 35.7 хувиар өссөн байна. | |
| 3 | | 1.1.3. Нэгдсэн эмнэлгийг коронавируст халдвар/covid-19/-ын оношилгооны PCR шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах. | 2021 | 0 | УТХО 1771,9 | | 2021 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Молекул биологийн лабораторийг шинээр байгууллаа. Лаборатори нь хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд технологи бүхий өндөр хүчин чадалтай ПГУ уншигч, нуклейн хүчил ялгах аппаратаар SARS-COV-2 илрүүлэх шинжилгээг хийж хариуг гарган үйлчилгээний хүлээгдлийг арилган, халдварыг эрт илрүүлж байна. Нийт 4048 хүний сорьцонд SARS-COV-2 илрүүлэх шинжилгээг хийж эерэг илрүүлэлт 1378 буюу 34,0%-тай байна. Урвалж бодисоор бүрэн хангасан. зарцуулсан санхүүжилт 17,718,436.99 | 100% / 100%Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг сая төгрөгөөр илэрхийлж системийн холбогдох талбарт тайлагнах. |
| 4 | | 1.1.4. Гамшгийн үед ажиллах | 2021 - 2024 | 50 1 | УТХО 3864,5 | 55 2 | 2021 онд Коронавирусын өвчлөл дэгдсэнтэй холбоотойгоор Монгол | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах. | | | | | улсын Шадар сайдын “Үнэлгээ хийх аргачлал батлах тухай” тушаалын дагуу болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах явцын үнэлгээг аймгийн хэмжээнд хийж Улсын онцгой комисст хүргүүллээ. Улсын онцгой комиссоос аймгийн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 80 эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. 2022-2024 оны хооронд Гамшгаас хамгаалах хуулийн 32 дугаар зүйлийн 32,1 дэх заалт , Монгол улсын засгийн газрын 2011 оны 339, 340 тогтоолын дагуу газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зарлан мэдээллэх дохиоллоор ажиллах дадлага сургуулилтад 10 автомашин, 242 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид бэлэн жагсаж сурган дадлагажсан. Нийт сурган дадлагажсан бүрэлдэхүүний тоо давхардсан тоогоор 342 болсон байна. зарцуулсан санхүүжилт 2,365,000 2021 онд Коронавируст халдварын үед ажиллах шуурхай хариу арга хэмжээний 5 багийг томилон эмнэлэг дэлгэх, эмнэлэг нүүлгэн шилжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг гаргаж Луус сумыг түшиглэн эмнэлэг дэлгэх сургалтыг онлайнаар зохион байгуулж нийт 65 эмч, эмнэлгийн мэргэжилтэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдлаа. 2022-2024 онуудад Эрүүл мэндийн албаны штаб, Мэргэжлийн ангийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ гамшгийн бэлэн байдалд ажиллаж аранзны үзлэг болон сургалтад мэргэжлийн 2 анги оролцож нийт 66 бүрэлдэхүүн хамрагдсан. Нийт давхардсан тоогоор 2 мэргэжлийн ангийн 200 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. зарцуулсан санхүүжилт 1.499.750 | |
| 5 | | 1.1.5. Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын 8 сургуульд нэвтрүүлэх | 2021 - 2024 | 0 | УТХО 625,8 ОНТ 260,0 Хандив тусламж 130,0 | 8 | Аймгийн хэмжээнд 19 сургуулиас 7 сургууль нь иж бүрэн цахим ангитай болж, интернэт тархцын тоног төхөөрөмжийг 17 сургууль буюу 89,5 хувийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр сайжруулан цахим шилжилт туршилтыг нэвтрүүлэн ажиллаж байна. 2024 онд Хүмүүнлэг, Говийн Ирээдүй сургуулиуд орон нутгийн 260,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахим ангийн тендер зарлагдаад байна. 2023-2024 онд 17 сургууль тус бүр 15-20 сая төгрөгийн wifi, тоног төхөөрөмжийг суурилуулж, дотуур байр, хичээлийн байрны анги танхимд интернэтийг бүрэн тарааж, цахим ангиудад 394 ширхэг таблет, 172 ширхэг chromebook, 28 ширхэг ухаалаг самбар, 66 ширхэг ухаалаг телевиз зэрэг тоног төхөөрөмжийг байршуулж, цахим шилжилтийг нэвтрүүлэх боломжийг хангаж ажиллалаа. Мөн БШУЯ-наас аймгийн 19 сургууль тус бүрт 2 | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ширхэг буюу нийт 40 ширхэг 99,4 сая төгрөг бүхий ухаалаг телевизийг цахим сургалтын хэрэгцээнд олгосон. Үүний үр дүнд eduten, peorson хөтөлбөрийн цахим хичээлүүд болон бусад цахим платформыг сургалтад ашиглах, сургалтын чанарыг дээшлүүлэх нөхцөл бүрдээд байна. | |
| 6 | | 1.1.6. Багш нарыг зөөврийн компьютерээр бүрэн хангах | 2021 - 2024 | 80 | УТХО 286,0 | 100 | 2021-2024 онд ерөнхий боловсролын сургуульд хуучин lenovo 273, шинэчилсэн нөүтбүүк 203 нийт 476 ширхэг нөүтбүүк багш нарын албан хэрэгцээнд ашиглагдаж багш нарын 95 хувь нь зөөврийн компьютероор хангагдсан бол 2024-2025 оны хичээлийн жилд яамны хөрөнгө оруулалтаар 251 ширхэг зөөврийн компьютер сургуулийн багш нарын албан хэрэгцээнд шинээр нийлүүлэгдэж энэ хичээлийн жилд нийт 454 буюу 85.3 хувиар зөөврийн компьютер шинэчлэгдээд байна. Сургуулийн өмнөх боловсролд БШУЯ-наас 50 ширхэг зөөврийн компьютерээр хангаж нийт багш нарын 50 хувь шинэ компьютероор хангагдсанаар сургуулийн өмнөх боловсролын багш нар 100 хувь хангагдаад байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын багш нарын компьютерын хангалт 97,5 хувьтай байна. | 87% / 87% |
| 7 | | 1.1.7. Цахим платформ ашиглан багш сурагчдыг сургалт | 2021 - 2024 | 2 55 | УТХО 8,9 | 10 75 | Багш, сурагчид Medle /цахим сургууль/, Suraad /Математик/, parent.edu.mn, bagsh.edu.mn, боловсролын удирдлага | 100% / 100%Үр дүнг нэгтгэн тайлагнах. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээнд хамруулах | | | | | мэдээллийн систем /ESIS/ платформуудыг нэвтрүүлэн ашиглаж боловсролын удирдлага мэдээллийн систем /ESIS/ 19 сургууль, 22 цэцэрлэгт нэвтрүүлж боловсролын салбарын мэдээллийг нэгтгэн хөгжүүлэлт хийгдэж байна. Дээрх цахим платформууд нь бэлэн хичээл, контентуудтай учир суралцагчдын байршлаас үл хамааран хоцрогдлыг арилгах, багшийн хичээлдээ бэлдэх ажлын ачааллыг бууруулахаас гадна сурагч нэг бүрийг үнэлдэг учир эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ бодит үнэлгээтэй танилцах боломжтой.Pearson /англи хэл/, Eduten /математик/, LMS+SMS, after school, гэрэгэ системийг хичээл сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж байна. Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа 2 цахим платформыг аймгийн ерөнхий боловсролын 19 сургуульд Eduten математикийн цахим платформыг 3-4-р ангийн 62 бүлгийн 1785 сурагч, Pearson англи хэлний цахим платформыг 5-6-р ангийн 1587 сурагчид ашиглаж байна. Сурах бичгийн түгээлт, хангалтыг хянах “Гэрэгэ” цахим системийг 19 сургуулийн номын санд нэвтрүүлээд байна. Дэлхий дахинд гарсан цар тахлын үед боловсролын үйлчилгээг тасралтгүй явуулах, сургалтын үйл ажиллагааг цахим, танхимын | Тухайн хэрэгжилтэд "ерөнхий боловсролын. ..ашиглаж байгаа" тайланг 2 удаа тайлагнасан байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хосолсон сургалтын арга хэлбэрээр зохион байгуулах зорилтын хүрээнд 2021-2024 онуудад дээрх платформуудыг нэвтрүүлэн сургалт үйл ажиллагаандаа тогтмол ашигласны үр дүнд багш нарын цахим орчинд ажиллах чадвар нэмэгдэн, ерөнхий боловсролын 19 сургуульд Eduten математикийн цахим платформыг 3-4-р ангийн 62 бүлгийн 1785 сурагч, Pearson англи хэлний цахим платформыг 5-6-р ангийн 1587 сурагчид ашиглаж байгаа нь боловсролын үйлчилгээний олон улсын жишгийг хөдөө орон нутагт туршин хэрэгжүүлж буй үр дүнтэй ажил боллоо. Сурагчдын хамрагдалт 100 хувьтай байна. | |
| 2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 8 | 2.1.1. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 байсныг 2024 он гэхэд 67.4 хувьд хүргэнэ. | 2.1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулах | 2022 | 0 | УТХО 2706.1 | | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр 2022 онд “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт байгуулж 1,152,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр ханган 347,8 сая төгрөгийн засвар үйлчилгээ, 35,626,3 төгрөгийн тавилга, эд хогшлийн хангалт хийж үйлчлүүлэгчид ээлтэй орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийг дэмжих төв ашиглалтад орсонтой холбоотойгоор зорилтот насны иргэдийн багцийн үзлэгийн үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс аймгийн хэмжээнд эхлүүллээ. УТХО | 100% / 90%Тайланг өссөн дүнгээр нэгтгэж тайлагнах. 2022 онд хэрэгжсэн ажлыг тайлагнахдаа эхлүүллээ гэж тайлагнаад байна. Багцын үзлэгийн үйл ажиллагаа 2024 онд ямар түвшинд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 270.615.247.6 | хэрэгжиж байгаа талаар тайлагнах нь зүйтэй. Тайланд өнгөрсөнд арга хэмжээ үргэлжлээд байна. Тайланд санхүүжилтийн хэмжээг тайлагнахдаа цэг таслал зөв бичих. (1,152,2 тэрбум гэсэн нь 1 их наяд 152 тэрбум 200 сая төгрөг үү, 35,626,3 энэ хэдэн төгрөг вэ?) |
| 9 | | 2.1.1.2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлэх. | 2021 - 2024 | 29 | УТХО 4.5 | 49 | 2021-2024 оны хугацаанд хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг календарчилсан төлөвлөгөөний дагуу хийж 52 сэдэв, чиглэлийн хүрээнд нийт давхардсан тоогоор 112058 иргэнийг хамрууллаа. “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, иргэн, өрх гэр бүл”-г шалгаруулах болзол, журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажилласанаар 2021 онд Эрүүл | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэндийг дэмжигч байгууллага, хамт олон 16 байсан бол 2024 оны байдлаар Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 50, эрүүл мэндээ дээдлэгч иргэн 24 болсон. УТХО 4.597.600 | |
| 10 | | 2.1.1.3. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах. | 2021 - 2024 | 45 33 | УТХО 3221.4 төсөл хөтөлбөр 30.0 ОНТ 40.0 | 54 34.0 | 2021 онд аймгийн хэмжээнд 12563 халдварт өвчлөл бүртгэгдэж байсан бол 2024 оны 11 сарын байдлаар 272 халдварт өвчин бүртгэгдэж 12339-өөр буурсан байна. 10000 хүн амд ногдох халдвар өвчний түвшин 2021 онд 2681.2 байсан бол 2024 онд 58.3 хувь болж буурлаа. Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэгт артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж -2, хөх, умайн хүзүүний өмөнгийн үзлэгүүдийг хийснээр 2021 онд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь 64.9 хувьтай байсан бол 2022 онд 62.8 хувьтай, 2023 онд 87,5 хувьтай болж 24,7 хувиар өссөн байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 76.8 хувьтай байна. 2021-2024 онд нийт 623389 хүнд үзлэг хийгдсэнээс 224567 хүнд урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 36.0 хувьтай байна. Гадаад хамтын ажиллагаа, компанит ажлын хүрээнд 2021 онд Улаанбаатар хотын Лев-Мед ХХК-ны эмнэлэгтэй хамтран 5 суманд 3344 иргэдэд явуулын нарийн мэргэжлийн амбулаторийн үзлэг, 2022-2024 онд | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монголын сумын эмч, эмнэлгийн мэргэжилтний холбоо болон аймгийн ЗДТГ-тай хамтарсан үзлэгт 1588, хүн амын нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 25499, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран томуугийн дархлаажуулалтын үзлэгт 18863, улаанбурхан улаануудын нэмэлт дархлаажуулалтын үзлэгт 4459, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч зудын гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 14 сумдад зохион байгуулсан үзлэгт 2096, Улсын Нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтарсан багц үзлэгт 1083 иргэнийг тус тус хамруулсан. Үзлэгээр нийт давхардсан тоогоор 56932 иргэнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, элэгний хавдар, элэгний цирроз, сүрьэ, ковидын дархаах хам шинж, уушигны хавдар зэрэг эрсдэлт бүхий өвчлөлийг илэрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт шилжүүлэн эмчилгээ оношилгоог хийлээ. 2021 онд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 33.3 байсан бол 2024 онд 35.8 хувь болж 2.7%-аар өссөн. | |
| 11 | | 2.1.1.4. Өвөр Монголын өөртөө засах орны | 2023 - 2024 | 0 | | 1 3500 | 2023 оны10 дугаар сарын 23 –ны 01/ 1340 дугаартай аймгийн засаг даргын албан бичгийг Өвөр | 0% / 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уламжлалтын эмчилгээ, оношлогооны эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулах. | | | | | Монголын өөртөө засах орны Баяннуур аймгийн Ардын засгийн ордонд явуулсан бөгөөд зөвшөөрөл олгогдоогүй гэдэг шалтгаанаар ирээгүй болно. Дахин Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02 –ны өдрийн 01/1385 албан бичгээр 2024 оны төлөвлөгөөнд оруулж хамтран ажиллах хүсэлтээ хүргүүлээд байна. Хариу ирээгүй байна. Энэ арга хэмжээ хийгдээгүй. | |
| 12 | | 2.1.1.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сумдын ИТХ-аар шийдвэрлүүлэх. | 2021 - 2024 | 86.5 82 | УТХО 18.1 | 90 88 | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/197 тушаалаар батлагдсан "Зайлшгүй шаардлагатай эмийн X жагсаалт батлах тухай" тушаалын дагуу эм болон эмийн чанар аюулгүй байдлыг хангаж, тасралтгүй, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн нийт 26 эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудад жил бүр 2-3 удаа хяналт хийснээр зайлшгүй болон амин чухал эмийн хангалт 90.2 хувьтай байна. 2021 онд зайлшгүй болон амин чухал 88.5 хувьтай байсан бол 2024 оны эхний 11 сарын байдлаар 91.3 хувьтай болж 2.7 хувиар өссөн байна. УТХО 17.067.891.60 2021-2024 оны хооронд төлбөрийг нь төр хариуцдаг эмийг давхардсан тоогоор хорт хавдартай 206, чихрийн шижинтэй 827, чихрийн бус шижинтэй 67, бамбай булчирхайн алдагдалтай 199, паркинсоны өвчин 4, нүдний | 83% / 83%"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-ийг үндэслэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даралттай 21, уналт таталт өвчтэй 223, сэтгэцийн өөрчлөлттэй 14, тиреотоксикозтой-12 зэрэг 9-10 төрлийн оноштой нийт давхардсан тоогоор 3114 иргэнд 112 000 000 төгрөгийн эмийн олгосон байна. 2021 онд төлбөрийг төр хариуцаж буй эмийн гүйцэтгэлийн хувь 87.0 хувьтай байсан бол 2023 онд 92.0 хувь олгож 4 хувиар өссөн байна. УТХО 1.146.574.28 Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 49 дугаар тогтоолоор "Эмийн эргэлтийн санг" татан буулгаж, хувьчлах тухай шийдвэрийн дагуу Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/277 дугаар захирамжаар “Эмийн эргэлтийн сан”-уудыг хувьчлах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 4 удаа хуралдан "Эмийн эргэлтийн санг"-уудын санхүү, хөрөнгө бусад нөхцөл байдлын талаар 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн ИТХ-д, 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдөр ИТХ-ын Төсөв, санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны хурлаар хэлэлцүүлж, санал дүгнэлтийг нэгтгэн дараагийн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээс хүлээгдэж байна. | |
| 13 | 2.1.2. Эхийн эндэгдэлгүй ажиллаж, тав хүртэлх насны хүүхдийн | 2.1.2.1. Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин | 2021 - 2024 | 194 | УТХО 43.3 хандив 14.2 | 300 | "Жирэмсний хяналтад шинээр жил бүр 600-700 жирэмсэн эх хамрагдаж жирэмсний эрт үеийн хяналт 4 жилийн дундаж 93.4 хувьтай байна. Аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад 94,9 | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эндэгдлийн түвшин 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9 хүргэж бууруулна. | нөхцөлийг сайжруулах | | | | | хувь төрж, жирэмсэн төрөх, төрсний дараах үеийн хүндрэл бүртгэгдээгүй. 2021 онд жирэмсний эрт хяналт 88.8 хувьтай байсан бол 2024 оны эхний 11 сарын байдлаар 96.7 хувьтай бол 7.9 хувиар өссөн. Эхийн эндэгдлийн тохиолдол сүүлийн 15 жил бүртгэгдээгүй. УТХО 16.595.363.1 хандив 14.257.800 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 4.0 промиль байна. 2021 онтой харьцуулахад 12.5 промилиор буурсан. 2021-2024 оны байдлаар эхчүүдийн амрах байраар нийт 719 эх амарч 3595 ор хоног ашигласан байна. Амрах байрны орчин нөхцөлийн сайжруулах чиглэлд эмнэлэг эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн нөөцөд тулгуурлан нийт 10.3 сая төгрөгний тохижилт хийсэн. Амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах төслийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эмч нар боловсруулан сумын Засаг даргын тамгын газарт орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр хүргүүллээ. УТХО 10.352.310 | |
| 14 | | 2.1.2.2. 0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх | 2021 - 2024 | 0 | УТХО 7.6 хандив 14.2 | 3 | 2021-2024 оны байдлаар хүүхдийг хоол тэжээлийн дутагдал, өсөлтийн хоцрогдлоос урьдчилан сэргийлэх, архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх зорилгоор зуны чийрэгжүүлэлт, Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүүхдийн сангаас хамтран хэрэгжүүлсэн “Гамшигийн үеийн нялх, бага | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | насны хүүхдийн хоол тэжээлийн дэмжлэг” төслийн хүрээнд чийрэгжүүлэн эрүүлжүүлэлтийг зохион байгуулж давхардсан тоогоор 15 сумын 0-5 хүртлэх насны 314 хүүхдийг хамруулснаас 205 хүүхдийг хоол тэжээлийн архаг дутал болон өсөлтийн хоцрогдлоос сэргийлж эрүүл мэндийг сайжруулж, хоол тэжээлийн дутлаас 94 хүүхдийг гаргасан байна. Нийт хоол тэжээлийн дутагдал илэрсэн хүүхдийг 100 хувь гаргасан байна. УТХО 7.600.000 хандив 14.257.800 | |
| 15 | 2.1.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ. | 2.1.3.1. Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологоор хангах | 2021 - 2024 | 0 | УТХО 1632.2 хандив 20.0 | 15 | 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт Компьютер томографыг улсын төсвийн 1 тэрбум 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар авч суурилуулж нэн шаардлагатай 347 эмчлүүлэгчид дүгнэлт гаргаж, хугацаа алдалгүй мэс засал болон эмийн эмчилгээг 347 иргэнд үзүүллээ. Хавдар 5, цус харвалт 12, хугарал 4, бөөрний чулуу 6, уушиг чалчийх 9, уушигны буглаа 3, нурууны сүрьеэ 2, элэгний олон уйланхай 1, тархины уйланхай 2, цөсний хүүдийн чулуу 15-ийг тус тус яаралтай оношлож 3 шатлалд очих урсгалыг бууруулж байна. УТХО 1.5000000000 2022 онд Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-овоо, Өлзийт, Дэлгэрхангай сумдын эрүүл мэндийн төвүүдэд 60,0 сая төгрөгийн үнэ бүхий мобайл технологи , 2023 онд Адаацаг, | 100% / 100%Зарцуул сан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг сая төгрөгөөр илэрхийлж системийн холбогдох талбарт тайлагнах. Тайланд санхүүжилтийн хэмжээг тайлагнахдаа цэг таслал зөв бичих. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сайнцагаан сумын эрүүл мэндийн төвд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон хувь хүний хандив тусламжаар мобайл технологи, 2024 онд Эрдэнэдалай, Гурвансайхан, Хулд, Луус, Дэлгэрцогт, Дэрэн сумдын эрүүл мэндийн төвүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мобайль технологи, Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төв нь гүйцэтгэлийн санхүүжилтээр мобайль технологитой боллоо. Ингэснээр мобайль технологийн үзлэг оношилгоог 5789 иргэнд хийж, 235 иргэнийг анхан шатны эрүүл мэндийн хяналтад авч, 150 иргэнийг эмчилж эрүүлжүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт 20 иргэнийг шилжүүллээ. Ингэснээр өссөн дүнгээр 15 сумын эрүүл мэндийн төвийн мобайль технологиор хангагдлаа. УТХО 132.179.000 хандив 20.000.000 | |
| 16 | | 2.1.3.2. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтыг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | 11 84.0 | | 14 93 | Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд 2021 оноос шилжиж одоо18 нэр төрөл, өрх, сумын эрүүл мэндийн төвүүд 2022 оноос эхлэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд бүрэн шилжсэн. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээ 18 нэр төрөлөөр сар бүр 90.0-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй авч байна. ЭМДС 496.367.128.88 Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд 2021 оноос шилжин нийт 53474.2 санхүүжилт авахаас 49636.7 сая | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгийн санхжүүжилт авч гүйцэтгэл 93.0 хувьтай байна. | |
| 17 | | 2.1.3.3. Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах. | 2021 - 2024 | 1 | УТХО 34.2 Хандив 6.2 ОНС 56.2 | 6 | "Сайнцагаан сумаар дамжин өнгөрөх Автозамын пост, Хулд, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвийг түшиглэсэн яаралтай тусламжийн цэгийг байгууллаа. Тус цэгүүдээр зам тээврийн осол 115, бусдад зодуулсан 23, уналт 17, хордлого 25, угаартсан 1, амьтанд хазуулсан 15, осголт 1, түлэгдэлт 15, мориноос унасан 2, хугарал бэртэл 10, хурц иртэй зүйлийн нөлөө 26 , мотоциклоос унасан 7 зэрэгт анхан шатны тусламж үйлчилгээ үзүүллээ. Сайхан-Овоо, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө. Ингэснээр 6 сумын эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн яаралтай тусламжийн цэгийг байгуулан яаралтай тусламжийн тоног төхөөөрөмжийн хангалт 79,5 хувьтай болж, нийт 257 хүнд яаралтай тусламжийг 100 хувь үзүүллээ. УТХО 34.289.700 Хандив 6.215.000 ОНС 56.235.000 " | 70% / 70% |
| 18 | | 2.1.3.4. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай | 2021 - 2024 | 45 1 90 | УТХО 2474.3 хандив 463.0 төсөл хөтөлбөр 416.5 ОНС 40.0 | 48 5.0 95 | 2021 онд эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг ДЭМБ байгууллага, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 163,8 сая төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, пульсоксиметр , халуун хэмжигч, амбу, Монитор , Автомакс зэрэг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох | | | | | нийт 10 төрлийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, 2022 онд эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 20,9 сая төгрөгийн хандив тусламжаар, 2023 онд яаралтай тусламжийн иж бүрдлийг 8 сумын эрүүл мэндийн төвүүдэд тус тус хуваарилан олголоо. Ингэснээр яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 55.3 хувьтай байсан 2024 онд 78.0 хувь болж 22.2 хувиар өссөн байна. Луус, Сайхан-Овоо сумд түргэн тусламжийн автомашиныг хүчилтөрөгч өтгөрүүлэгч, амбу, хэл дарагч, ларингоскопи, гэмтлийн бэхэлгээ, зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар, Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 157,6 сая төгрөгийн өртөг бүхий түргэн тусламжийн иж бүрэн тоноглогдсон эмнэлгийн автомашиныг олгож, Дэлгэрхангай, Баянжаргалан Эрдэнэдалай, Говь-Угтаал, Өлзийт, Өндөршил, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг нийт 64.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тус тус тоноглолоо. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт улсын төсвийн 198,0 сая хөрөнгө оруулалтаар Patrol маркын автомашин, Нарлаг Монголын тээвэр зууч" Нямхишиг транс" ХХК | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийгмийн хариуцлагын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт 123,0 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон. Ингэснээр эмчлүүлэгчид газар дэрээ түргэн тусламжийг авах таатай нөхцөл бүрдэж нийт тоноглогдсон машин 11 боллоо. 2021-2024 оны хооронд Эрүүл мэндийн салбарт 44.2 хувьд автомашины парк шинэчлэлт хийлээ. Автомашин хангалт 98.0 хувьтай болж 4 хувиар өссөн байна. | |
| 19 | | 2.1.3.5. Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютерээр хангах | 2021 - 2024 | 0 15 | УТХО 1177.7 хандив 4.4 | 30 50 | Эрүүл мэндийн төвүүд нь лавлагаа шатлалын эмнэлгээс алсын зайн оношилгоог 117 тохиолдол дээр авч цахимаар авлаа. Төрөлжсөн нарийн мэргэжлийн төвөөс эмчилгээ оношилгооны зөвлөгөөг 15 удаа, гэмтлийн үеийн тусламж үйлчилгээ, эмийн чанар аюулгүй байдал, олон улсын эмнэлзүйн программ хэрхэн ашиглах, хүүхэд болон насанд хүрэгчдийн томуугийн эмчилгээ, гамшгийн үеийн сэтгэлзүйн тусламж зэрэг 25 сэдвээр нийт давхардсан тоогоор 125 удаагийн цахим зөвлөгөө мэдээлэл хүргэлээ. Лавлагаа шатлалын эмнэлгээс 4 жилийн хугацаанд нийт 117 тохиолдол дээр цахим зөвлөгөө авч цаг алдалгүй эмнэлгийн тусламжийг үзүүлж эмчилгээ, оношилгоо 100 хувь үр дүнгээ өгсөн. УТХО 998.156 2021-2024 онд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, 15 сумын Эрүүл мэндийн төв, 2 өрх, Уламжлалт | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | анагаах ухаанй Нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв зэрэг нийт 21 байгууллагуудын оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэл, дархлаажуулалт, санхүүд зориулан суурин 95, зөөврийн 17 нийт 112 компьютероор хангагдсан. Эрүүл мэндийн газар алсын зайн сургалт мэдээллийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдаж, өрх сумдын Эрүүл мэндийн төвүүдтэй зайнаас холбогдох боломж бүрдсэн. Ингэснээр нийт компьютерын тоо 112 болж хангалт 100 хувь болсон. УТХО 179.678.910 хандив 4.400.000 | |
| 20 | 2.1.3.1. Эмнэлэгүүдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ. | 2.1.3.1.1. Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих. | 2021 - 2024 | 11 | | 3 | Сайнцагаан сумын 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгын угсралтын ажлыг 2019 онд “Тэнгэрийн тэмдэг” ХХК 8,752,9 сая төгрөгийн санхүүжилтэйгээр гэрээ байгуулж 3 жилийн хугацаанд баригдан 2023 онд үлдэгдэл 1300,0 төгрөгийг суулгаснаар 100 ортой шинэ барилга ашиглалтад орж үйл ажиллагааг эхлүүлэн иргэдэд үйлчлэх таатай, ээлтэй орчин бүрдлээ. 2024 оны улсын төсөвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн барилгыг эхлүүлнэ. Өндөршил, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг хойшлогдсон. УТХО 86.013.654.11 | 0% / 0% |
| 21 | | 2.1.3.1.2. Нэгдсэн эмнэлгийн | 2022 - 2024 | 2 0 | УТХО 587.5 ОНС 861.1 | 6 1 | 2021-2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэдалай | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | амбулатори, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгуудад их засвар , Боржигон мандал, Өлзийт мандал ,Гурванса йхан сумын эрүүл мэндийн төвд өргөтгөл хийх. | | | | | сумын эрүүл мэндийн төв гадна талын тохижилтын ажил, орон нутгийн хөгжлийн сангийн 172,7 сая төгрөгөөр Эрдэнэдалай, Гурвансайхан, Дэлгэрцогт, Өндөршил, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвүүдэд их засвар, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлгийн завсар, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварууд 100 хувьтай хийгдэж дууссан. Зооноз өвчин судлалын төвийн шинэ барилгын бариулахаар газрыг шийдүүлэн, техникийн нөхцөл шаардлагыг гаргалаа. Нийт засвар хийгдсэн эмнэлгийн тоо 8 болсон. УТХО 86.013.654.11 Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл хийж хүүхдийн тусламж үйлчилгээ, лабораторийн тусламж үйлчилгээ зэрэг эмчилгээ үйлчилгээний тоо нэмэгдэж, иргэд үйлчлүүлэх таатай орчин бүрдлээ. Боржигонмандал өрхийн эрүүл мэндийн төвийг цэвэр, бохир ус, нийтийн халаалтад холбохоор зураг төслийн ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж өргөтгөлийн барилгыг 2025 онд барихаар хойшлогдсон.УТХО 501.563.60 ОНС 861.125.600 | |
| 22 | | 2.1.3.1.3. Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл | 2021 - 2024 | 78.5 91.2 | УТХО 916.0 ОНТ 861.1 ХАНДИВ 13.5 | 80.0 93.5 | 2021 онд улсын төсвиин 2601.6 сая төгрөгийн 19 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр, 2022 онд улсын төсөв болон хандивлагч байгууллагуудын санхүүжилт 741.2 сая төгрөгийн 40 нэр төрлийн тоног | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангах | | | | | төхөөрөмжөөр, 2023 онд хандивлагч байгуулага болон улсын төсвийн хөрөнгө оруулалт 146.9 сая төгрөгийн 14 төрлийн тоног төхөөрөмжийг тус тус олгосон байна. 2024 онд Баянжаргалан, Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвүүд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 төрлийн тоног төхөөрөмж, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь 12 орыг тус тус худалдан авч орчин нөхцөлөө сайжрууллаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зудын нөхцөл байдалтай холбогдуулан Өлзийт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдад 2 төрлийн нийт 20.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 68 багийн эмч нарын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор 53.6 сая төгрөгийн багийн эмчийн үзлэгийн цүнхийг тус тус хандивлан өглөө. Сум өрхийн тоног төхөөрөмжийн хангалт 89.1 хувьтай болж 2021 оноо 10.1 хувиар өссөн байна.УТХО 50.156.360 ОНС861.125.600 2021 онд улсын төсөв болон хандивлагч байгууллагын санхүүжилтээр зөөврийн дижитал рентген аппарат, амьсгалын аппарат, дижитал зөөврийн рентген, нуклейн хүчил ялгагч машин, унтуулгын аппарат, дурангийн аппарат, амьсгалын аппарат зэрэг 96 нэр төрлийн 3110,8 сая төгрөгийн, 2022 онд улсын төсвийн хөрөнгө | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулалтаар уян дурангийн иж бүрдэл, суурин болон зөөврийн эхо аппарат, шүдний кресло, тархины пофлер, зэрэг 31 нэр төрлийн 846.6 сая төгрөгийн, 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар уян дуран, рентген зэрэг 16 нэр төрлийн 2000.0 сая төгрөгийн, 2024 онд улсыг төсөвийн хөрөнгө оруулалтаар зүрхний эхо, хог хаягдлын автоклав, ходоодны уян дуран, элиза уншигч аппарат зэрэг 8 нэр төрлийн 473.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тус тус хангагдсан байна. 2021-2024 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 6843.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжтэй болж хангалтын хувь 95.2 хувь болж 3.2 хувиар өссөн.УТХО 54.978.900.00 ХАНДИВ 13.568.650.00 | |
| 23 | | 2.1.3.1.4. Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох хөдөлгөөнийг үе шаттай өрнүүлэх. | 2021 - 2024 | 52.4 | УТХО 4.2 | 85 | “Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай Эрүүл мэндийн байгууллага” шалгаруулах болзолт уралдааныг зарлан зохион байгуулж болзол, журмын дагуу дүгнэн шалгаруулснаар эрүүл мэндийн анхан шатны 15 байгууллагаас 13 нь буюу 86,6 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. УТХО 4.225.000 | 100% / 100%Үр дүнг бүрэн тайлагнах, тайланд нотлох баримт хавсаргах |
| 24 | 2.1.4. Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 96.7 хувь байсныг 2024 он гэхэд | 2.1.4.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл | 2021 - 2024 | 41.8 | УТХО 134.4 | 45 | "Эрүүл мэндийн салбарт нийт 720 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд гэрт 26,3 хувь, орон сууцанд 56,7 хувь, бусад нөхцөлд 17 хувь нь амьдарч байна. Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Өндөршил, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 97.5 хувьд хүргэнэ. | бүрдүүлэх замаар орон сууцаар хангах | | | | | Говь-Угтаал, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, Өндөршил, Цагаандэлгэр, Адаацаг, Эрдэнэдалай, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгт шинээр төгсөж ирээд ажиллаж байгаа 49 албан хаагчийг орон байраар хангаж, ажиллаж байгаа 48 албан хаагчийг Ипотекийн 6 хувийн орон сууцны зээлэнд хамруулсан. 2021-2024 онд нийт 112 албан хаагч орон байрны нөхцлөө сайжруулсан байна. Ингэснээр орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь 2021 онд 42.0 хувьтай байсан бол 2024 он эхний 10 сарын байдлаар 56,7 хувьтай болж 14.7 хувиар өссөн байна. УТХО 134.400.000 | |
| 25 | | 2.1.4.2. Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэх | 2021 - 2024 | 94 8 | УТХО 746,0 | 96.9 43 | 2021-2024 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт лаборатори, дотор, эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, ходоодны дуран судлал, чих хамар хоолой, арьс, хавдар, дүрс оношилгоо, нярай, компьютер томографи, сэтгэл засал, сэргээн засах, бөөр, зүрх, клиник эм зүйч, хавдрын хими эмчилгээ, эмэгтэйчүүдийн дуран зэрэг нийт 18 чиглэлээр 25 нарийн мэргэжлийн эмч нарыг, Адаацаг сумын эрүүл мэндийн төвд хүүхэд, эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, Дэлгэрцогт сумын эрүүл мэндийн төвд гэмтэл согог засал, Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төвд хүүхэд, мэс засал судлал, эрүүл мэндийн удирдлага, | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боржигон мандал өрхийн эрүүл мэндийн төв, Цагаандэлгэр, Хулд, Говь-Угтаал, Өлзийт, Өндөршил, Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвийн эмчийг хэвлийн хөндийн хэт авиа судлалаар нийт 13, Зоонозын өвчин судлалын төвд зоонозын өвчин судлал, Эрүүл мэндийн газарт талбарын тархвар судлал, эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, орчны эрүүл мэнд судлалын 4 нарийн мэргэшлийн нийт 42 эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэнг нарийн мэргэшлээр бэлтгэсэн. Ингэснээр нарийн мэргэжлийн эмчийн хнагалт 97%-тай болж 2%-иар өссөн байна.УТХО 732.890.00 Аймгийн нэгдсэн эмнэлэгт мэс засал, ариутгал, мэдрэл, дархлаажуулалт, яаралтай, гемодиализ, бичил амь судлал, хүүхэд, халдварт, чих хамар хоолой, компьютер томографийн техникч зэрэг нарийн мэргэжлийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нийт 23, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд дархлаажуулалт,серилоги судлал, ариутгал, хүүхэд, нийгмийн эрүүл мэндийн судлал, бүртгэл мэдээлэлийн чиглэлээр нийт 32 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг тус тус бэлтгэн ажиллуулж байна. 2021-2024 онуудад нийт 55 нарийн мэргэшлийн сувилагч, тусгай мэргэжилтэнг бэлтгэж 49-өөр нэмэгдэн орон нутгийн иргэдэд нарийн мэргэжлийн тусламж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээг үзүүлж байна. УТХО 12.300.000 | |
| 26 | | 2.1.4.2.1. Анагаахын их сургуулиудтай хамтран ажиллаж орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 83.3 | УТХО 63.6 | 87.0 | 2021 онд Глобал удирдагч дээд сургуультай хамтран 25 сувилагчтай гэрээ байгуулан 3 жилдээ суралцаж байна. Аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" хөтөлбөрийн хүрээнд төгсөх ангийн 12 оюутаны сургалтын төлбөр 24,290 сая төгрөгийг төлж орон нутагт ажиллуулаа. 2021-2024 онуудад нийт эмнэлэг, эрүүл мэндийн төвд 28 сувилагч шинээр төгсөж ирээд орон нутагтаа ажиллаж байна. Нийт 153 сувилагч ажиллахаас 134 сувилагч ажиллаж байгаа бөгөөд сувилагч мэргэжилтний хангалт 87,6%-тай байна. УТХО 63.599.500 | 70% / 30%Тус арга хэмжээний 2023 оны тайланд стандартын дагуу 166 сувилагч ажиллана гэснийг 153 болгож, зорилтот түвшинг бууруулж тайлагнасан байна. - Мөн хүрсэн түвшин 145-аас 134 болж буурсан байна. - Мөнгөн дүн зөв тайлагнах. |
| 27 | | 2.1.4.2.2. “Ахмадын ордон”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-д ахмад настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээг | 2021 - 2024 | 0 | УТХО 4.7 | 4 | Дорноговь аймгийн Анагаах ухааны сургуультай хамтран ажиллаж сэргээн засах тусламж үйлчилгээний чиглэлээр нийт 15 сумын эрүүл мэндийн төвүүдэд 15 сувилагч, тусгай мэргэжилтэнг бэлтгэлээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв шинээр ашиглалт орж 4 их эмч, 1 сэргээн засалч, нийгмийн эрүүл мэндийн ажилтанг мэргэшүүлэн сургаж ажиллуулж байна. Ахмадын ордонд | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзүүлэх мэргэшлийн хүний нөөцийг сурган бэлтгэх | | | | | аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахмадын эмч давхар хариуцан ажиллаж байна. 2021-2024 онуудад нийт 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэлээ. УТХО 4.700.000 | |
| 28 | | 2.1.4.3. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн нарийн мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг туршлага судлуулж, сургалтад хамруулах | 2022 - 2024 | 44 | УТХО 26.7 | 79 | 2021-2024 онуудад ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Индонез, Банконг зэрэг 8 оронд удирдлага, зооноз, уламжлалт,сувилахуй, нүдний чиглэлээр нийт 104 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дадлагажуулах болон туршлага судлах сургалтад хамрууллаа. Мөн Монгол-Японы эмнэлэгтэй хамтран ажиллаж "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах" чанарын туршлага судлах сургалтад 42 эмч мэргэжилтэн хамруулсан байна. УТХО 26.720.000 | 100% / 100% |
| 29 | 2.2.1. Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 25193 байсныг 2024 онд 28105-д хүргэнэ. | 2.2.1.1. Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх | 2021 - 2024 | 8125 | УТХО 3,2<br>ОНТ 4,8 | 12340 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагдсан “Эрүүл Монгол”, “Эрүүл чийрэг Дундговьчууд” аяны хүрээнд аймгийн хэмжээнд 15 сум, 18 заал, 5 клуб, 9 танхим, 43 байгууллага дээр давхардсан тоогоор нийт 25295 иргэн идэвхитэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэж байна. Өглөөний алхалт, зөөлөн гүйлт, дугуй унах, дасгал, бүжиг, явган аялал, спортоор хичээллэх, нийтийг хамарсан спортын арга хэмжээнд нийт 10627 иргэн хамрагдлаа. Мөн 11 дүгээр сарыг Соёлын бүтээлч сар болгон | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зарласантай холбогдуулан Биеийн тамирын бүтээлч сар аяныг зохион байгуулж, Эрүүл Дундговьчууд уриан дор иргэдийг дасгал хөдөлгөөнөөр хичээллэх боломжийг бүрдүүлэн өглөө 07:00-08:00 цагт спорт зааланд Говийн наран бүжгийн клубын багш Б.Наранхүүгийн удирдлага дор дасгал хөдөлгөөн, шугаман бүжгийг иргэдэд заан, хичээллүүллээ. Идэвхитэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэгсдийн тоо 35020-д хүрсэн байна. | |
| 30 | | 2.2.1.1.1. Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх | 2021 - 2024 | Спортын холбоодтой хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо Спорт хамтлагуудтай хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | УТХО 59,0 ОНТ 34,0 Хандив 16,5 | 16 38 | Аймаг, улсын нийт 17 спортын холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан Улсын болон аймгийн аварга шалгаруулах 45 тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулсан. Мөн улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох эрхийн төлбөр, байр, хоол, унааны зардал, бэлтгэл, сургалт явуулах заал танхимаар ханган үйл ажиллагаанд нь 18.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 39 байгууллагын спорт хамтлаг, холбоодтой хамтран, “Илүүдэл жингүй эртэч монгол” аян, бие бялдрын түвшин тогтоох сорил, салбарын нэрэмжит тэмцээн уралдаан зэрэг нийт 45 арга хэмжээнд давхардсан тоогоор 3500 иргэнийг хамруулж оролцуулсан. | 70% / 70% |
| 31 | | 2.2.1.1.2. Монгол | 2021 - | 70 | Хандив 10,0 | | 2022 оны 06 дугаар сарын 23-29-ны | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | улсын гавьяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит өсвөрийн волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах | 2022 | | | | өдрүүдэд Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит Өсвөрийн волейболын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын волейболын холбоотой хамтран амжилттай зохион байгуулсан. Тус тэмцээнд 19 аймаг, 9 дүүрэг, 8 клубийн нийт 86 багийн 1200 гаруй тамирчид оролцсон. | |
| 32 | | 2.2.1.1.3. "Бага олимп" наадмыг 2 жил тутамд зохион байгуулах | 2023 | 7 | ОНТ 35,0 | | ""Бага олимп – 2023" наадмыг 11 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд Мандалговь хотноо зохион байгуулж, шилдгүүдээ тодрууллаа. Тэмцээнд 14 сумын 654 тамирчин оролцож, шагай харваа, даам, шатар, бадминтон, ширээний теннис, дартс, буудлага, сагсан бөмбөг, гар бөмбөг гэсэн нийт 9 төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Багийн нийлбэр дүнгээр Сайнцагаан сумын баг тамирчид тэргүүн байрыг эзэлж, Луус сум, Говь-Угтаал сумын баг тамирчид удаах байранд шалгарч, цом, мөнгөн шагналын эзэд боллоо. 2 жил тутам зохион байгуулагддаг энэхүү спортын арга хэмжээг зохион байгуулснаар спорт сонирхогчдын тоо нэмэгдэж байна. " | 100% / 100% |
| 33 | | 2.2.1.1.4. Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлыг зохион | 2022 - 2024 | 8 34 | УТХО 46,0<br>ОНТ 25,6<br>Хандив 3,0 | 38 | "Үндэсний спортын наадамд сур, шагай, уран уургач, бугуйлч, эмнэг сургагч, бөх, ширээний шагай, байт харваа, морьт харваа, зэрэг спортын 9 төрлөөр нийт 46 иргэн оролцсон. Сурын харваанд | 100% / 70%Зорилтот түвшинд бүрэн хүрээгүй. "Бодлогын |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | | | | | багаараа мөнгөн медаль, хувийн цуваанд мөнгөн медаль, эмнэг сургагчаар хүрэл медалийг тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн. " 2023 оны 08 дугаар сард Дэрэн сумын нутагт шагайн харвааны холбоотой хамтран Наран хөгцтийн шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд хурууний 15 багийн 120 харваач, чавхний 7 багийн 56 харваач нийт 22 багийн 176 харваач оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдсөн. Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлын хүрээнд Үндэсний сурын харваа тэмцээнийг 3 удаа, өвлийн харваа тэмцээнийг 1 удаа, үндэсний бөхийн барилдааныг 3 удаа, үндэсний шагайн харваа тэмцээнийг 3 удаа, Хаврын бүсийн морин уралдаан 1 удаа тус тус зохион байгуулсан бөгөөд тус тэмцээнүүдэд нийт 42 баг оролцон байна. 2024 оны 08 дугаар сард зохион байгуулагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 6 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, Үндэсний уламжлалт спорт, тоглоом, наадгайн түүх, онцлог, амжилтууд, үндэсний спортын төрлөөр Дундговь аймгаас төрөн гарсан алдар цуутай хүмүүсийн талаарх мэдээлэл, шагайн наадгай, оньсон тоглоом, үндэсний шагайн харваа, үндэсний сурын харвааны эдлэл, хэрэгслээр гэрээ тохижуулан, гадаад дотоодын 670 | баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.2.2-ыг үндэслэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гаруй үзэгч, зочид төлөөлөгчдөд тайлбарлан, танилцууллаа. Монголын хүүхдийн спортын наадам 2023 оны 6 дугаар сарын 17-ноос 6 дугаар сарын 30 хүртэл Баянхонгор аймагт зохион байгуулагдаж, нийт- 97 тамирчин, 14 дасгалжуулагч усан сэлэлт, чөлөөт бөхөөс бусад спортын 11 төрөлд оролцож алтан медаль-1, мөнгөн медаль-2, хүрэл медаль–3 хүртсэн амжилтуудыг үзүүлсэн. | |
| 34 | | 2.2.1.1.5. Сагсан бөмбөгийн 3х3 спортын төрлийг орон нутагт дэмжин хөгжүүлэх | 2021 - 2024 | 3х3 спортын төрлөөр хичээллэгдийн тоо 3х3 спортын багш, дасгалжуулагч, шүүгчээр бэлтгэгдсэн хүний тоо | УТХО 8,3 ОНТ 0,8 хандив 0,1 | 5200 26 | Аймгийн хэмжээнд нийт 15 сумын 5200 иргэн 3х3 сагсан бөмбөгийн спортоор хичээллэж байна. "Сургуулийн биеийн тамирын багш болон клубийн дасгалжуулагч зэрэг нийт 25 багш дасгалжуулагчид сургалт зохион байгуулж, 3х3 спортын шүүгчээр бэлтгэсэн. Мөн Дундговь аймгийн сагсан бөмбөгийн холбооны нарийн бичиг, шүүгчид тоглолтын статистик хөтөлгөөний программ дээр ажиллах сургалт авлаа. Сургалтыг Монголын сагсан бөмбөгийн холбоо болон Олон улсын сагсан бөмбөгийн холбооны статистик шүүгч И.Норжин зохион байгууллаа. Тус сургалтад нийт 8 багш хамрагдлаа." | 70% / 70% |
| 35 | | 2.2.1.2. Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, спортын талбайг байгуулах | 2021 - 2024 | 73 0 | ОНТ 2029,2 | | Гүйцэтгэгчээр Зуут констракшн ХХК ажиллаж барилга болон спортын талбайн ажлыг 2022 онд 100 хувь ашиглалтад оруулсан. Цэнгэлдэх хүрээлэнгийн ажлын гүйцэтгэгчээр “Зуут Констракшин” ХХК ажиллаж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжүүлсэн. Тус хүрээлэнгийн спортын талбайд үндэсний сурын 10 зурхайтай шинэ талбай, шагайн харвааны 8 багийн тоглолтын талбай зэргийг ашиглалтад оруулсан. Цэнгэлдэх хүрээлэнгийн гаднах спортын талбайн тохижилтод 3220м2 бүхий 120 авто машины зогсоолыг орон нутгийн хөгжлийн сангийн 200 сая төгрөгийн хөрөнгөөр оруулалтаар хийсэн. | |
| 36 | | 2.2.1.3. Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулах | 2021 - 2024 | 0 | УТХО 9401,5 | 70 | Зэд прожект" ХХК-тай гэрээ байгуулан, усан бассейн бүхий спорт цогцолборын зураг, төсвийг гүйцэтгүүлэн, барилгын хөгжлийн төвөөр батлуулж хэрэгжүүлсэн. Усан бассейн бүхий спорт цогцолборын ажлыг 2024 онд улсын төсвийн 4.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэлийг "Жи жи ай" ХХКомпани хоёр давхрын карказ, суурийн дүүргэлт зэрэг ажлыг хийж гүйцэтгээд байна. 2024 онд тус барилгын явцад 2 удаа хяналт тавьж ажиллалаа. 2024 онд барилгын гүйцэтгэлийн ажил 77 хувьд хүрсэн байна. | 100% / 90%Үр дүнг бүрэн тайлагнах, тайланд нотлох баримт хавсаргах, ямар ажлууд хийснээр барилгын гүйцэтгэлийг 77 хувьд хүрсэн гэж үнэлсэн тодорхойгүй тул үнэлгээг 1 шатлал бууруулж тооцов. |
| 37 | 2.3.1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 72.5 хувь | 2.3.1.1. Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Адаацаг, Хулд, Цагаандэлгэр суманд шинээр | 2023 - 2024 | 2 | УТХО 7200,0 | 50 4 | Сайнцагаан сумын 2-р цэцэрлэг, Дэлгэрцогт сумын цэцэрлэгийн барилгыг 2023 онд ашиглалтад хүлээн авсан. Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн Барилгын газар шороо, суурь, каркас, гадна дотор ханын өрлөг, гадна цахилгаан | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байсныг 2024 онд 76 хувьд хүргэнэ. | цэцэрлэгийн барилга барих | | | | | холбоо, ариутгал татуургын шугамын ажил хийгдэж зогссон. 2024 онд 1,061.5 төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2025 онд улсын төсвөөс үлдэгдэл санхүүжилт 2,285.2 сая төгрөг төсөвт суугдсан. 2025 онд барилгын ажил дуусахаар төлөвлөгдсөн байна. Нийт 3 цэцэрлэгийн хөрөнгө шийдвэрлэгдэж Сайнцагаан сумын 2-р цэцэрлэг, Дэлгэрцогт сумын цэцэрлэгүүд ашиглалтад орж, Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын ажлын явц 65 хувьтай байна. | |
| 38 | | 2.3.1.2. Цэцэрлэгийн бүлгийн багш нарыг хөгжим тоглох ур чадварт сургана. | 2021 - 2024 | 0 | УТХО 4,0 | 60 | Аймгийн 22 цэцэрлэгт нийт 112 бүлгийн багш хүүхэд хөгжүүлэх төрийн үйлчилгээг хэрэгжүүлэв. Багш нарын хөгжмийн боловсролыг дээшлүүлэх, бага насны хүүхдийг багаас нь авъяас чадварыг хөгжүүлэх, ажлын байрандаа хөгжим тоглох чадвараа нэмэгдүүлэн ажиллах чиглэлээр жил бүр үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэн ажилласны үр дүнд давхардсан тоогоор даралтад хөгжмийг 65 багш, чулуун хөгжмийг 3 багш, үндэсний хөгжмийг 12, нийт 7 төрлийн хөгжмийг нийт 90 багш сурч, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвшсэн нь нийт багшийн 80.3 хувийг эзэлж, багш нар ажлын байрандаа хөгжим тоглох ур чадвараа ажлын байрандаа хөгжүүлсэн байна. Хөгжим тоглож сурсан бүлгийн | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | багшийн чадварыг үнэлэх, хүүхдийн хөгжлийг үнэлэх зорилгоор цэцэрлэгийн багш нарын дунд аймгийн Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр болон хүүхдийн хөгжлийг дэмждэг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудаас нийт 8 удаагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 1200 гаруй хүүхдийг хамруулсан, мөн цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хүүхдийн хөгжлийн үр дүн 2024 онд 91.3 хувьтай дүгнэгдсэн үр дүнг үзүүллээ. | |
| 39 | | 2.3.1.3. СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | 2 | УТХО 76,9 | 22 | 2021 онд нийлүүлсэн Эх соёл- Эх үндэсийн хөрөнгө оруулалтаар .... төгрөгийн тоног төхөөрөмжийг олгосон. Аймгийн 22 цэцэрлэгт дуу хөгжмийн болон биеийн тамирын кабинет байгуулах ажлыг жил бүрийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлсний үр дүнд 2021-2024 онуудад дуу хөгжмийн 18, биеийн тамирын 4 кабинетыг шинэчлэн болон шинээр байгуулан тохижуулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган ажиллав. Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, аймаг, орон нутгийн санхүүжилтээр Сайнцагаан сумын 3,4 дүгээр цэцэрлэгүүдийг дуу хөгжмийн 18 нэр төрлийн 49 ширхэг хэрэглэгдэхүүн, тоглоомоор, Сайнцагаан сумын 7, Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумын цэцэрлэгүүдэд 50 ширхэг морин хуур, 9 төрлийн тоног төхөөрөмж | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүхий пианика хөгжим-105, микрофон-15, иж бүрэн зөөврийн чанга яригч 6 ширхэгийг олгон, Биеийн тамирын кабинетыг тохижуулахад модон шат, хэрэглэгдэхүүний багц-14, матрасс-30, нуман шат, зөөлөн гар бөмбөг-32 ширхэгийг нийлүүлж, бага насны хүүхдийг бие бялдар, авъяас чадварыг хөгжүүлэх орчин нөхцлийг сайжруулав. Хүүхдийг хөгжүүлэх хөгжмийн болон биеийн тамирын кабинет байгуулахад нийт 76.9 сая төгрөгийг зарцуулсан болно. | |
| 40 | 2.3.2. ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 91.6 хувь байсныг 2024 онд 96.5 хувьд хүргэнэ | 2.3.2.1. Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, сумдад шинээр сургуулийн барилга барих | 2021 - 2024 | 0 | УТХО 31116,0 | 80 1 | Сайхан-Овоо сумын сургуулийн барилгыг 2022 оны 12 сарын 16-ны өдрийн 39/2022 тоот дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Сайнцагаан сумын Говийн ирээдүй, Хүмүүнлэг сургуулийн барилгын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 3 сургуулийн хөрөнгө шийдвэрлэгдэж Сайхан-Овоо сумын сургууль, Сайнцагаан сумын Говийн ирээдүй, Хүмүүнлэг сургуулийн барилга 100 ашиглалтад орсон. | 75% / 75% |
| 41 | | 2.3.2.1.1. Сайнцагаан сумын ЕБС-ийг түшиглэн олон улсын жишигт нийцсэн ЕБС-ийг байгуулах | 2024 | 0 | | 1 | Дундговь аймгийн Цэгцбилиг сургууль нь математикийн гүнзгийрүүлсэн сургалттай сургууль бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилээс гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиудыг төрөлжсөн сургалттай сургууль болгож 6-12 дугаар ангийн нийт 14 бүлгийн 447 хүүхэд математикийн төрөлжсөн хөтөлбөрөөр хичээллэж байна. Цэгцбилиг сургуульд суурилан | 0% / 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ахлах сургууль байгуулах бэлтгэл ажил хангагдаж судалгаа хийж ажиллаж байна. Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургуулийг олон улсын жишиг сургууль болон хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Шинэ хуульд нийцсэн дүрэм журамтай холбоотойгоор 2023-2024 онд яамны тус хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй тасарсан. | |
| 42 | | 2.3.2.1.2. Хулд сумын ЕБС-ийн барилгын их засварын ажлыг хийх | 2024 | 0 | | 1 | Хулд сумын сургуулийн барилгын их засварын зураг төсөв хийгдэж магадлангаар баталгаажсан. 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд бүртгүүлсэн. | 30% / 30% |
| 43 | | 2.3.2.2. Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад шинээр дотуур байрын барилга барих | 2021 - 2024 | 1 | УТХО 2410,0 ОНТ 100,2 | 50 2 | Адаацаг сумын дотуур байрны барилгын санхүүжилтыг 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын цахим системийн санд бүртгүүлсэн. Говь-Угтаал сумын дотуур байрны барилгын ажлын явц 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Дэлгэрхангай сумын дотуур байрны хувьд нийт 199.6 сая төгрөгийн өртөгтэй их засварын санхүүжилт батлагдсан бөгөөд 2024 онд 100.25 сая төгрөг санхүүжигдэж энэ жилийн ажлын явц 100 хувьтай байна. Гурвансайхан сумын ЕБСургуулийн 100 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны барилгыг 2022 оны 12 сард ашиглалтад өгсөн. Шинээр барих Говь-Угтаал сумын дотуур байрны санхүүжилт шийдэгдэж барилгын ажлын явц 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Дэлгэрхангай сумын дотуур байрны их засвар | 50% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийх санхүүжилт шийдэгдэж энэ жилийн хувьд ажлын явц 100 хувь байна. Дэлгэрхангай сумын сургуулийн дотуур байранд их засварын ажлыг ОНХС-ийн 100.248.887 төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэв. | |
| 44 | | 2.3.2.3. Гадаад хэл болон байгалийн ухааны судлагдахууны багш нарыг гадаад оронд мэргэжил дээшлүүлэх | 2022 - 2024 | 0 | ОНТ 67,0 | 2 | Гадаад хэл болон байгалийн ухааны хичээлийн багш нарыг гадаад оронд туршлага судлуулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж, 2022 онд 4 багш, 2023 онд 19 багш, удирдах ажилтан, 2024 онд 12 багш, удирдах ажилтан нийт 35 багш, удирдах ажилтнууд Япон, Солонгос, Англи, Оросын холбооны улсуудад 7-21 хоног мэргэжил дээшлүүлсэн нь тэдний гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлсэн ажил болж, Сайнцагаан сумын Мандал сургууль Япон улсын сургалтын байгууллагын менежментийг 4 жил тасралтгүй сайжруулан хэрэгжүүлсний үр дүнд сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 2-р индекст шалгагдсан үр дүнг үзүүллээ. Мэргэжил дээшлүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 67.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. | 100% / 100% |
| 45 | | 2.3.2.3.1. Оюутан суралцагчтай гэрээ хийх замаар нэн шаардлагатай мэргэжлийн багшийн | 2021 - 2024 | 0 | ОНТ 33,0 | 8 | Аймгийн хүний нөөцийг бэхжүүлэх орон нутагтаа боловсон хүчнийг татан ажиллуулахад тодорхой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, хөрөнгө зарцуулж байна. Боловсролын салбарт | 70% / 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангалтыг нэмэгдүүлэх | | | | сүүлийн 2021-2023 онуудад шинээр төгсөгчдөд төлбөрийг даан гэрээгээр 11 багш орон нутагтаа ирээд ажиллаж байна.2024 онд 7 оюутантай гэрээ байгуулсан. Энэхүү үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс нийт 33.0 сая төгрөгийг зарцуулсан байна. | |
| 46 | | 2.3.2.4. Улс, аймгийн туршлагатай багш нарыг түшиглэн сургалт, чансаа тогтоох сорилуудыг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог ахиулах | 2021 - 2024 | 498.4 | ОНТ 210,4 | 506 | Аймгийн хэмжээнд элсэлтийн шалгалтын оноог ахиулах зорилтыг тавьж МУБИС, Оюунлаг сургуулийн удирдлагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан 2 удаагийн давтамжтайгаар судлагдахууны багш нарыг сургалтад хамруулсан. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар элсэлтийн ерөнхий шалгалтад багаараа бэлтгэн амжилт гаргасан багш нарыг урамшуулах журмыг батлуулж хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн 2 жилд элсэлтийн шалгалтын онооны хүрэх түвшин буюу 2023 онд 506, 2024 онд 509 буюу 3 оноогоор ахисан үзүүлэлттэй дүгнэгдэв. Хичээлийн жилийн эхэнд бүрэн дундын 8 сургуулиуд элсэлтийн шалгалтад бэлтгэх төлөвлөгөөг боловсруулан баталж, аймгийн Боловсролын газраас тухайн жилд зохион байгуулах сорилын хуваарийг батлан гаргаж, 2021-2024 онуудад 24 удаагийн сорилд 1548 шалгуулагчдыг 10 хичээлээр хамруулан дүн оноог бэлтгэж буй мэргэжлийн багш нарт танилцуулан ажиллаж, “Гранд Ай Ти компанийн “ЭЕШ-800” дата | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | анализын программыг ашиглан 3 удаагийн сорилыг авч, дүгнэлт хийн ажилласны үр дүнд 5 төгсөгч 800 оноотой шалгуулсан амжилтыг үзүүлж, монгол хэлний хичээлийн элсэлтийн шалгалтаар 2024 онд улсад тэргүүлж, физик 3-р байрт эрэмбэлэгдсэн амжилтыг үзүүлэв. | |
| 47 | | 2.3.2.4.1. Бага, суурь боловсролын багш нарыг 100 хувь зөвлөх багийн үйлчилгээнд хамруулах | 2021 - 2024 | 50 50 | УТХО 40,0 | 100 100 | Аймгийн ерөнхий боловсролын 19 сургуульд бага боловсролын 159 багш ажиллаж байна. Аймгийн Боловсролын газраас тухайн хичээлийн жилийн намар 9 сард, хавар 5 сард нийт 8 удаагийн зөвлөн туслах үйлчилгээг тусгай баталсан удирдамж, чиглэлийн дагуу ажлын 3 хэсэг аймгийн 15 суманд очиж, 2021-2024 онуудад давхардсан тоогоор бага ангийн 638 багшийг 100 хувь хамруулж, тэдний суралцахуйн үйлд ажиглалт хийж, багш нэг бүртэй хичээлийн хэлэлцүүлэг, нэгжийн болон ээлжит хичээлийн бэлтгэл, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдэж байгаад дүн шинжилгээ хийж ажилласны үр дүнд Боловсролын үнэлгээний төвийн хөндлөнгийн үнэлгээний шалгалтаар бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 2022 онд 52 хувь, 2023 онд 52.2, 2024 онд 57.1 хувийн гүйцэтгэлтэй шалгагдсан үр дүнг үзүүлсэн болно. Боловсролын газрын Даргын баталсан удирдамжийн дагуу 2021-2024 онуудад 8 удаагийн зөвлөн | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | туслах ажлыг зохион байгуулж, аймгийн ерөнхий боловсролын 19 сургуулийн суурь, бүрэн дунд боловсролын нийт 363 багш нар 100 хувь хамрагдаж, давхардсан тоогоор 1344 багш нарын нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт, улсын болон анги дэвших шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажилтай танилцан, хичээлд суун зөвлөн тусалж, тэдний төлөвлөлт, арга зүйг дээшлүүлэн, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсний үр дүнд багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хөндлөнгийн шалгалтаар 2022 онд-72.5 хувь, 2023 онд -75.2, 2024 онд 75.6 хувьтай тус тус шалгагдаж, 2022 онд улсад аймгийн боловсролын салбар 5-р байранд эрэмбэлэгдсэн амжилтыг үзүүллээ. Мөн Боловсролын яам, Боловсролын ерөнхий газрын 2022-2024 онуудын төлөвлөгөөт сургуулийн менежментийн зөвлөн туслах үйлчилгээнд аймгийн 19 сургуулийн 57.8 хувь буюу Сайнцагаан сумын Говийн ирээдүй, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Адаацаг зэрэг 11 сургууль хамрагдасны үр дүнд сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр нийт сургуулийн 12 буюу 63.1 хувь нь 1-4-р индекст үнэлүүлж, урамшуулалд хамрагдлаа. | |
| 48 | | 2.3.2.5. Чадварлаг багш арга хэмжээг | 2021 - 2024 | 0 | УТХО 247,3 | 85 | "“Чадварлаг багш” хөтөлбөрийн хэрэгжилт, төлөвлөлтийг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх | | | | | сургалтын 41 байгууллагаас тоон тайлан авч нэгтгэн дүгнэж, цэцэрлэг, сургуулийн тайлангийн хурлаар хянан хэлэлцэхэд 87.5 хувьтай дүгнэгдэв. Чадварлаг багш хөтөлбөрийн багшийн онолын мэдлэгийг дээшлүүлэх зорилтыг аймгийн Эрдэнэдалай, Гурвансайхан, Сайнцагаан сумын Эрдмийн далай, Цэгц билиг, Мандал сургуулиуд үр дүнтэй хэрэгжүүлснээр элсэлтийн ерөнхий шалгалтын дүн өмнөх оноос 4 хичээлийн гүйцэтгэл 1,36-12,46 оноогоор ахиж, Сайхан-Овоо, Өлзийт, Дэлгэрхангай, Адаацаг, Баянжаргалан, Дэрэн сумд багшийн хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэхэд санаачилгатай ажиллан багшийн хөгжлийн төв байгуулан, Баянжаргалан, Дэлгэрхангай, Цэгц билиг, ГИЦС багш нарын улсын төрөлжсөн олимпиадад багш суралцагчдыг амжилттай бэлтгэн, багшаа чадваржуулж, 4 багш, 4 суралцагч улсаас эхний байруудад шалгарсан үр дүнг үзүүллээ. Мөн эрдэм шинжилгээний бага хуралд аймгийн сургууль, цэцэрлэгийн илтгэлүүд улсад 3-р байр, тусгай байрт тус тус шалгарсан нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж байна. ЕБС-ийн хэмжээнд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 206 удаагийн сургалт арга хэмжээнд нийт 4240 багш нар хамрагдан 73.2 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс арга хэмжээний тоо 10-аар, гүйцэтгэлийн хувь 2.2 хувиар өссөн дүн мэдээтэй байна. | |
| 49 | | 2.3.2.5.1. СӨБ, ЕБС-ийн багш нарыг дотоодод туршлага судлуулах | 2021 - 2024 | 27 | ОНТ 17,5 | 60 | Аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэгүүдийн удирдлага, багш ажилтнуудыг дотоодын буюу өөрийн болон бусад аймгуудад туршлага судлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх санаачилгыг дэмжин ажилласны үр дүнд 2021-2024 онуудад нийт 81 удаагийн туршлага солицох уулзалтад 652 албан хаагчид оролцон, Улаанбаатар хотын Оюунлаг, Шинэ монгол сургууль, Дорнод, Говь-Сүмбэр аймгийн 1-р сургуулиуд болон өөрийн аймгийн сургуулиудад туршлага судлах ажлыг зохион байгуулсан дүн мэдээтэй байна. Энэ ажлын хүрээнд аймгийн Мандал сургууль 5 жил туршин хэрэгжүүлж байгаа “Сургуулийн менежментийн төлөвлөлт зураглал боловсруулах” туршлагыг Өлзийт, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрхангай сумдад зөвлөн тусалснаар 4 сургууль зураглалаа боловсруулсан, Өндөршил сумын сургууль “Судалгаат хичээл, туршилтат хичээлийн зохион байгуулалт, багш нарын бүтээлч байдал” туршлагаа Баянжаргалан, Говь-Угтаал сумын багш нарт түгээн дэлгэрүүлсний үр дүнд багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 3 | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | багш түвшин ахисан үзүүлэлттэй шалгагдав. Гурвансайхан, Өндөршил сумдын цэцэрлэгийн 41 багш ажилчид УБ хотын 154,164,52-р цэцэрлэгүүдэд туршлага судалж мэргэжил арга зүйгээ дээшлүүлсэн. Мөн 1-5 жилдээ ажиллаж байгаа СӨББ-ын 21 залуу багш “Сайн хичээл-2023, 2024” арга хэмжээнд оролцож бие биеэсээ туршлага судалсан нь залуу багш нарт үр дүнд хүрсэн ажил боллоо. Туршлага судалснаар сургууль, цэцэрлэгүүд байгууллагын менежментээ сайжруулах, төлөвлөлтөө хийхэд хувь нэмрээ оруулж, нийт 42 сургалтын байгууллагаас 40 нь буюу 95,3 хувь сургалтын байгууллагын менежментийн зураглалаа боловсруулж, төлөвлөлтөө боловсруулдаг арга зүйтэй болов. | |
| 50 | | 2.3.2.5.2. ЕБС-ийн урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | 2 2 | УТХО 623,3 төсөл 800,0 | 19 19 | Дуу хуур, өв соёлын нутгийн хүүхэд багчуудын авъяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үе шаттай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, "Их соёл-Эх үндэс” хөтөлбөрийн хүрээнд 19 сургуулийн хөгжмийн кабинетад, 800.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсгээр, энэ хичээлийн жилд 19 сургуулийн хөгжмийн хичээлийн кабинетад 378.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн нийлүүлж, сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлсэн бөгөөд өмнөх | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | онуудад кабинетын гэрчилгээтэй 14 сургууль байсан бол энэ хичээлийн жилд Сайхан-Овоо сумын сургууль хөгжмийн кабинет шинээр байгуулан, гэрчилгээжүүлж аймгийн хэмжээнд нийт 15 сургууль хөгжмийн кабинетыг хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Шинээр өгсөн хэрэглэгдэхүүнийг ашиглан гитарын сургалтыг сурагчдын сонирхол, хэрэгцээнд тулгуурлан өнгөрсөн хичээлийн жилээс тогтмол зохион байгуулж аймгийн хэмжээнд 150 орчим сурагчийг сургалаа. Ерөнхий боловсролын 19 сургууль хичээл практикийн зардлаас 245,0 сая төгрөгийг биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнд зарцуулсан байна. Биеийн тамирын зааландаа засвар үйлчилгээ хийсэн Баянжаргалан, Говийн ирээдүй цогцолбор сургуулийн бага сургууль байна. Кабинетын шаардлага хангасан 15 кабинет ажиллаж байна. Адаацаг сумын ЕБС спорт заал шинээр ашиглалтад орсон. 2023-2024 оны хичээлийн жилд 7 нэмэгдсэн. | |
| 51 | | 2.3.2.6. Аймгийн Насан туршийн төв, сумдын насан туршийн нэгжүүдээр дамжуулан 9-12-р ангийн | 2021 - 2024 | 32 | УТХО 40,0 | 40 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжил сонголтын сургалтыг 8-12-р ангийн давхардсан тоогоор 1545 сурагчдад албан байгууллагуудтай хамтран зохион байгуулж хамрагдах ёстой сурагчдыг 100% | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулах | | | | | хамруулсан. Боловсрол нөхөн олгох сургалтад 2024 онд 22 хүүхэд суралцаж сургалтад хамрагдах ёстой сурагчдын тоо 100 хувь буюу бүрэн хамрагдсанаар сургалтын явцын үр дүн гарч байна. НТБТөв, сумдын нэгжийн багш нар амьдрах ухааны 8 чиглэлээр 254 сургалтыг 40,950 иргэнд зохион байгууллаа. | |
| 52 | | 2.3.2.7. Сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим байгуулах | 2021 - 2024 | 0 | УТХО 59,9 ОНТ 40,9 Хандив 5,0 төсөл хөтөлбөр 159,3 | 13 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимыг Эрдмийн далай, Говийн ирээдүй, Цэгцбилиг, Мандал, Сайхан-Овоо, Баянжаргалан, Дэлгэрцогт, Луус, Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай, Гурвансайхан сумын ерөнхий боловсролын сургуулиудад нийт 265.1 сая төгрөгийн улсын болон орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр байгууллаа. 2021-2024 онуудад нийт 13 сургуульд танхим байгуулахаас 12-т нь байгуулж, хэрэгжилт 75 хувьтай байна. Хөгжлийн танхимыг байгуулснаар сүүлийн сургуулийн насны 156 хүүхдээс 111 хүүхэд нь ЕБС, насан туршид суралцаж, хамран сургалт 71.1 хувьтай байна. Хамран сургалт нэмэгдсэнээр ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сурч хөгжих эрхийн хувь нэмэгдсэн үр дүн гараад байна. Зарцуулсан санхүүжилт-265.1 сая төгрөг | 50% / 50% |
| 53 | | 2.3.2.8. Сургууль | 2021 - | 3 | УТХО | 26 | Аймгийн ерөнхий боловсролын 19 | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүрт байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах | 2024 | | 230,0 ОНТ 54,0 төсөл 66,0 хандив 30,0 | | сургуулиудад байгалийн ухааны кабинетуудыг байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, 2024-2025 оны хичээлийн жилийн 12 сарын байдлаар байгалийн ухааны 28 кабинеттай болж, хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Энэ оны 9 сард Говь-Угтаал сумын сургуульд Д.Сэрээтэр багшийн нэрэмжит байгалийн ухааны цахим кабинетыг 20.0 сая төгрөгийн хандиваар тохижуулж, "Боловсролын чанар" хөтөлбөрийн хүрээнд Говийн ирээдүй, Хүмүүнлэг, Цэгц билиг, Гурвансайхан Говь-Угтаал 5 сургуульд байгалийн ухааны кабинетыг нийлүүлэх тендерийг зарлахаар хүлээгдэж байна. Кабинет байгуулахад нийт 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсөв хандив тусламжаар бүрдүүлээд байна. | |
| 54 | | 2.3.2.9. Сургууль, дотуур байрыг 100% шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, дотор ОО-той болгох | 2021 - 2024 | Дотор нойлтой сургуулийн тоо Дотор нойлтой дотуур байрны тоо Усанд орох нөхцөл бүрдсэн дотуур байрны | УТХО 1085,0 | 19 18 18 | Ерөнхий боловсролын 19 сургуулиас 18 сургууль нь дотор ариун цэврийн байгууламжийг ашиглаж 95 хувьтай байна. Аймгийн 18 дотуур байраас 16 дотуур байр буюу 88.8 хувь нь дотор нойл, усанд орох нөхцөлийг бүрдүүлээд байна. Дэлгэрцогт сумын нэгдсэн шугам сүлжээ шийдэгдэхгүй байгаагаас гадна нүхэн жорлон ашиглаж байна. Дэлгэрцогт сумын ОНХС-гийн хөрөнгөөр сумын цэвэр, бохирын нэгдсэн шугам сүлжээг холбох ажлыг үе шаттайгаар зохион | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тоо | | | байгуулж байгаа бөгөөд 2024 оны 10 сарын байдлаар цэвэр усны шугамын холболтыг хийж гүйцэтгээд байна. Говь-Угтаал сумын сургуулийн дотуур байр шинэ барилгын хамт ариун цэврийн байгууламж ашиглалтад орох бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. Говь-Угтаал, Адаацаг, Дэрэн сумын сургуулиас бусад 13 дотуур байр усанд орох нөхцөл бүрдсэн. Говь-Угтаал, Адаацаг суманд шинэ дотуур байр барихаар ирэх жилийн хөрөнгө оруулалтад төлөвлөсөн. | |
| 55 | | 2.3.2.10. Цэцэрлэг, сургууль , дотуур байрны гадаад дотоод орчныг бүрэн камержуулах | 2021 - 2024 | 50 | ОНТ 120,0 | 90 | Цэцэрлэгийн хувьд камержилт 100 хувь, дотуур байрны камержилт 90 хувь, сургуулийн камержилт 100 хувь байна. Камерын хүчин чадлыг сайжруулах ажил цэцэрлэгүүдэд бүрэн хийгдсэн. Камертай сургууль, цэцэрлэг, дотуур байрны эзлэх хувь 90,2 байна. | 100% / 100% |
| 56 | | 2.3.2.11. "Дундговь-боловсролын чанар" төсөл хэрэгжүүлэх | 2023 | 0 | ОНТ 600,0 | | "Аймгийн Засаг даргын 2024 оны 225 дугаар захирамжаар баталсан мэргэжлийн багш нарыг багаар урамшуулах журмын хэрэгжилтийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд нийт 18 сургуулийн бага ангийн 24 багийн 148 багш, суурь боловсролын 21 багийн 83 багш, бүрэн дунд боловсролын 27 багийн 158 багш буюу нийт 72 багийн 389 багш нар шалгаруулалтад оролцлоо. Үүнээс сургуулийн өмнөх боловсрол 3, бага боловсрол 6, суурь боловсрол 6, бүрэн дунд боловсролын 9, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удирдах ажилтны 9 нийт 33 багийн 149 багш удирдах ажилтнуудад нийт 251,0 сая, Элсэлтийн шалгалтын дүн оноогоо улс аймгийн дунджаас ахиулсан багш нарт 93 сая төгрөгийн урамшууллыг Орон нутгийн төсвөөс 343,0 сая төгрөгийн урамшууллыг олгосон нь тэднийг урамшуулсан, нийгмийн хамгааллыг дэмжсэн үр дүнтэй ажил болов. Сумдын Засаг даргын Тамгын газрын удирдлагуудтай хамтран 3-4, 6-9, 10-11-р ангиудын суралцагчдын сурлагын хоцрогдлыг анги хамт олноор арилган нөхөх, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний бичгийн шалгалтын хувийг ахиулах, харилцан туршлага солилцох зорилгоор монгол хэл, математик, геометр, англи хэл, үндэсний бичиг, хими биологи, мэдээллийн технологи гэсэн 8 хичээлээр анги нийтийн олимпиадыг амжилттай зохион байгуулж, 230 бүлгийн давхардсан тоогоор 8049 суралцагчид хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс оролцогчдын тоо 3534 суралцагчдаар, аймгийн гүйцэтгэлийн дундаж 2,6 хувиар өсөж, 43,6 хувьтай дүгнэгдсэн сайн үзүүлэлттэй байна. Энэ олимпиад нь сурлагын хоцрогдлыг арилгах, анги нийтээр нь стандартыг хангуулахад хувь нэмрээ оруулж байна. " | |
| 57 | 2.3.3. | 2.3.3.1. | 2021 | 0 | УТХО 8,0 | | 2021 оны 9 дүгээр сарын 8-10-ны | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | МСҮТөвийг Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж болгож, төгсөгчдийн ажил эрхлэлт 2020 онд 65 хувь байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ. | Байгууллагын магадлан итгэмжлэлд орох | | | | | өдрүүдэд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс томилогдсон сургуулийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргах магадлан итгэмжлэлийн шинжээчдийн баг ирж ажиллаж, байгууллагын магадлан итгэмжлэлд орсон. | |
| 58 | | 2.3.3.2. Багшлах бүрэлдэхүүний боловсролын зэргийг ахиулан магистрын сургалтад хамруулах | 2021 - 2024 | 13 | УТХО 8,0 | 21 | 2024-2025 оны хичээлийн жилд нийт 37 багштай сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 19 буюу багшлах бүрэлдэхүүний 51.3% нь магистр зэрэгтэй багш байна. 2024 онд магистрын сургалтад хамрагдсан 3 багшид 2,288,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ хичээлийн жилээс магистрын сургалтад шинээр 3 багш суралцаж байна. | 70% / 75%"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-ийг үндэслэв. |
| 59 | | 2.3.3.3. Техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг барилга болон хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр боловсруулж, дүгнэлт гаргуулах | 2022 - 2023 | 0 | УТХО 4,0 | | Дундговь аймаг дахь Политехник коллеж нь 2021 онд нийт 4 мэргэжлээр Техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2022 онд ХАА-н чиглэлийн 2 хөтөлбөр буюу Малын бага эмч, Зоотехникч мэргэжлийн хөтөлбөрүүдийг боловсруулан МБСҮМАЗТ-өөр дүгнэлт гаргуулсан. 2023 онд Барилга угсралтын техникч мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулан дүгнэлт | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гаргуулсан. | |
| 60 | | 2.3.3.4. Хөдөө аж ахуйн мэргэжлийн кабинетыг байгуулах | 2022 | 0 | УТХО 45,0 | | Хөдөө аж ахуйн мэргэжлийн 1 кабинетыг шинээр байгуулж, 4.000.000 төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн. Мөн малын бага эмч, зоотехникч мэргэжлийн лаборатори байгуулах төсөл боловсруулан холбогдох газруудад хүргүүлж байна. | 100% / 100% |
| 61 | 2.4.1. Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 2020 онд 11198 байсаныг 2024 онд 12218-д хүргэнэ | 2.4.1.1. Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 5 | | 9 | Тус газар нь 2021 онд 5 нэр төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байсан бол 2024 онд тэтгэмжийн даатгалын сангаас олгож байгаа 4 төрлийн тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой 4 үйлчилгээ нийгмийн даатгалын лавлагаа мэдээлэлтэй холбоотой 6 үйлчилгээ, нийт 14 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлэн иргэд даатгуулагч нарт үйлчилж байна. | 100% / 100% |
| 62 | | 2.4.1.2. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 15 | УТХО 16,6 | 35 | 2021-2024 онд нийгмийн даатгалын цахим үйлчилгээнд 8348 тэтгэвэр авагч, 7173 заавал даатгуулагч, 445 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 515 жирэмсэн болон амаржсаны тэтгэмж тэтгэмж авагч, 146 оршуулгын тэтгэмж, 177 ажилгүйдлийн тэтгэмж, 4238 сайн дурын даатгуулагч нийт 21042 даатгуулагч иргэн 14 нэр төрлийн цахим үйлчилгээгээр үйлчлүүлснээр өнгөрсөн 2021 оноос 29,51 хувиар өссөн байна. | 100% / 100% |
| 63 | 2.4.2. 2019 оны байдлаар ажиллаж байгаа 22040 | 2.4.2.1. Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж байнгын | 2021 - 2024 | 25 | УТХО 8789,7 | 120 | "Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй санхүүгийн дэмжлэг, жижиг зээл, хоршоо хөгжүүлэх сан, жижиг дунд | 100% / 100%Үр дүнг бүрэн тайлагнах, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэний ажлын байрыг 2200 -аар нэмэгдүүлнэ. | ажлын байранд зуучилж, бүртгэлжүүлэн, ажлын байртай болгох | | | | | үйлдвэрлэлийг дэмжих зээлд 2021-2024 онд 424 иргэн, 29 ААНБ-д 8789,7 төгрөгийн санхүүжилт олгож, 453 иргэний байнгын ажлын байрыг бий болгож ажиллалаа. | тайланд нотлох баримт хавсаргах |
| 64 | | 2.4.2.2. 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах | 2021 - 2024 | 50 | УТХО 380,3 ОНТ 17,0 | 53 | 2021-2024 онд 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн насны ажилгүй 881 /давхардсан тоогоор/ иргэн байснаас байнгын ажлын байранд 795 иргэн буюу 90 хувийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, 260 өрхийг үйлчилгээнээс түдгэлзүүлж, Луус, Цагаандэлгэр, Өндөршил, Говь-Угтаал сумдыг хүнсний эрхийн бичиггүй сум болгож зорилтод бүлгийн хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийг ажил хөдөлмөрт зуучлан өрхийн орлогыг нэмэгдүүлж, халамжаас хөдөлмөрт зорилтыг хэрэгжүүлж ажиллалаа. | 100% / 100% |
| 65 | | 2.4.2.3. Түр ажлын байранд иргэдийг зуучилж ажлын байртай болгох | 2021 - 2024 | 173 | УТХО 919,9 | 600 | 2021-2024 онд 2013 иргэнийг түр ажлын байранд зуучилж хөдөлмөр эрхлэлтийн ejob програмд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 41.1 хувийг түр ажлын байраар хангаж ажиллалаа. | 100% / 100% |
| 66 | 2.4.3. Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага 2019 онд 24 байсныг 2024 онд 36-д хүргэнэ. | 2.4.3.1. Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд тогтмол хамруулах | 2021 - 2024 | 37.2 | ОНТ 20,2 | 60 | Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд давхардсан тоогоор 20887 ахмад настан буюу жилд бүр дунджаар 78.9 хувь нь тогтмол эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна. Ахмад настны эрүүл насжилтыг дэмжих, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар аймгийн хүн амын дундаж наслалт | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 74.8 буюу улсын дунджаас 3.3 жилээр их болсон байна. | |
| 67 | | 2.4.3.2. Ахмад настнуудыг нас,бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах | 2021 - 2024 | 1200 | ОНТ 107,2 | 1425 | Ахмад настнуудыг нас, бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах ажлын хүрээнд 13 сумын Ахмадын хороог софть волейбол, граундгольфийн техник хэрэгсэлтэй болгож сургалт, жил бүр Илүүдэл жингүй эртэч Монгол, Энэ жилдээ эрүүл жиндээ зэрэг алхалт дасгал хөдөлгөөний аян зохион байгуулж, аймгийн төвд ахмадын дасгал хөдөлгөөний талбай байгуулсан. Үүний үр дүнд тайлант хугацаанд алхалт дасгал хөдөлгөөнд 9265, софть волейболоор 71, цэнгээнт бүжгээр 596, унадаг дугуйгаар 80 ахмад настан нийт 10012 ахмад настан тогтмол дасгал хөдөлгөөнд хамрагдаж байна. | 100% / 100% |
| 68 | | 2.4.3.3. Аймгийн ахмадын спорт, урлагийн бага наадмыг зохион байгуулах | 2021 - 2024 | 135 | | 145 | 2021-2024 онд 2 удаа урлагийн наадам, 2 удаа спортын наадмыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 632 ахмад настан хамрагдсан байна. Мөн аймгийн ахмадын урлаг, спортын бага наадамд оролцсон ахмад настнууд говийн бүсийн их наадамд оролцож 2024 онд тэргүүн байр эзэлсэн. Мөн монголын хөнгөн атлетикийн Ахмадын холбоотой хамтран Олон Улсын хэмжээний мастер, Цагдаагийн хурандаа Ц.Найдангийн нэрэмжит Хөнгөн атлетикийн Ахмад мастеруудын Улсын аварга шалгаруулах | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэмцээнийг зохион байгуулж, орон нутгийн хөрөнгө оруулалтын Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас 3,620,000 төгрөгийг зарцуулсан. | |
| 69 | | 2.4.3.4. Аймгийн ахмадын байгууллагын түүхийн ном хэвлүүлэх | 2022 | 0 | ОНТ 10,0 | | Ахмадын байгууллага /түүхэн цаг үе/ номыг 200 ширхгийг хэвлэн гаргаж олны хүртээл болгосон. | 100% / 70%Тайлан хангалтгүй. Өмнөх тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу тайлан сайжруулаагүй байна. Ахмадын байгууллага /түүхэн цаг үе/ ном хэвлүүлэх зорилго, шалтгаан, ач холбогдол, үр дүнг тайлагнаагүй байна. |
| 70 | 2.4.4. Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилт 2019 онд 51 хувь байсныг 2024 онд 59 хувьд хүргэнэ. | 2.4.4.1. "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 65-аас доошгүй хувийг чадваржуулах сургалтад хамруулах " | 2021 - 2024 | 25 | ОНТ 10.8 | 65 | Нийгмийн бүлгүүдийн өмнө хуулиар үүрэг хүлээгчдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, хөгжил оролцоог дэмжих, хамтарсан багийг арга зүйгээр хангах, чадавхжуулах, | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвлөн туслах хүрээнд 15 төрлийн сургалтыг нийт 13800 хүнийг хамруулан хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг чадваржуулах зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Нийт 10.843.900 төгрөгийг зарцуулсан. | |
| 71 | | 2.4.4.2. “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд дээвэр, халуун ус, ариун цэврийн шинэ байгууламж, сагсан бөмбөг, гар бөмбөг, тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулах | 2022 - 2023 | 2 | ОНТ 310,0 | | 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Бүрдийн уянга зуслангийн Мандал, Сансар байрны дээврийн их засвар хийгдэж, бороо гоожихгүй болсон. Хүүхэд хөгжих таатай орчин бүрдсэн. 2023 онд 270 хүүхэд, 2024 онд 374 нийт 644 хүүхэд зуслангийн хөгжлийн үйлчилгээнд тэгш хамруулсан | 70% / 30%Зорилтот түвшинд хүрээгүй. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.2.4-ийг үндэслэв. |
| 72 | | 2.4.4.3. Хүүхдийн паркийг стандартын дагуу орчин үеийн тоглоомтой болгох | 2022 - 2024 | 0 | ОНТ 90,0 | 3 | 2022 онд 90 сая төгрөгийн 4 нэр төрлийн тоглоомыг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. Хүүхдүүдийн тоглох тоглоомын тоо нэмэгдсэн. | 50% / 50%Тоглоом гэдгийг шалгуур үзүүлэлтээр тодорхой зааж өгөх шаардлагатай байна. Бүтээц, хийц, шинж чанар |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гэх мэт, 1 хүүхэлдэй байсан ч тоглоом гэж үзэх тул шалгуур үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай. |
| 73 | | 2.4.4.4. Хүүхдийн паркийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл шинээр хийх | 2023 | 0 | ОНТ 20,0 | | 2023 онд 20 сая төгрөгөөг 82 ширхэг гэрэлтүүлгийг Сайнцагаан сумын сум хөгжүүлэх сангаас шийдвэрлэж хүүхдийн тоглох ая тухтай орчныг бүрдүүлж ажилласан. | 100% / 97.6%"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-ийг үндэслэв. |
| 74 | 2.4.5. Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын дундаж хувь 2019 онд 22.3 байсныг 2024 онд 45 хувьд хүргэнэ | 2.4.5.1. Залуучуудад чиглэсэн төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 3315 4000 | ОНТ 16,0 | 5000 7000 | "Залуучуудад чиглэсэн төрийн үйлчилгээг дэмжих чиглэлээр дараах 5 чиглэлийг үйл ажиллагааг зохион байгуулсан байна. 1. Хувь хүний хөгжлийн дэмжих чиглэлээр 10 сэдвийн сургалтыг 2901 залуучуудад 2. Боловсрол, соёл урлаг спортыг дэмжих чиглэлээр 4 чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулж 2435 залуучууд 3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжих үйлчилгээ: /300/ 4. Аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 25 сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулж, 338 залуучууд 5. Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ чиглэлээр 2 үйл ажиллагаа зохион байгуулж, 724 залуучуудыг тус тус хамруулж, нийт 6698 залуучуудыг хамруулсан байна. Залуучуудын нийгмийн хөгжилд оролцох оролцоо өмнөх оноос 8.4 хувиар нэмэгдсэн байна. " | |
| 75 | | 2.4.5.2. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх | 2023 - 2024 | | ОНТ 8,0 | 2 85 | .Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний А/108 дугаар захирамжаар Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг 15 гишүүнтэйгээр шинэчилсэн байгуулсан. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр зохион байгуулж, ээлжилт хуралдаанаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Залуучуудын салбар зөвлөлийн дүрэм, залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлэх зэрэг 3 асуудлыг танилцуулж хуралдааныг зохион байгууллаа. Хуралдаанд нийт гишүүдийн 92 хувь нь оролцсон байна. Хуралдаанаар залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар 8 санал, санаачилга гаргаж, салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмжийг гаргасан. | 50% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хуралдаанаар салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг 100 хувийн саналтайгаар батлав. 2. Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Говийн өнгө-Говийн залуус" арга хэмжээ зохион байгуулах тухай А/586 тоот захирамжын дагуу Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн гишүүд 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 2 дахь хурадааныг 12 гишүүн, холбогдох мэргэжлийн байгууллагын 11, нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй, хуралдаж, үйл ажиллагааны бэлтгэл ажлыг зохион байгуулах талаар хэлэлцсэн. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн төлөвлөгөөг 2 зорилт, 13 арга хэмжээтэй төлөвлөгөөг Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн тэргүүн, аймгийн Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.Төлөвлөгөөний хэрэгжилт 92.3 хувьтай байна. | |
| 76 | | 2.4.5.3. Залуучуудыг хариуцлагатай иргэн болоход нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулах | 2022 - 2024 | 1 50 | ОНТ 13,0 | 4 300 | 2021 онд Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Зэвсэгт хүчний жанжин штабтай хамтран залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, соёл уламжлалаа түгээх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Эх оронч залуу” үндэсний аян эх орон даяар нэгэн зэрэг зохион байгуулагдлаа. Тус аянд аймгийн төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын төлөөллүүд болох Онцгой байдлын газар, Цагдаагийн | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн албан хаагч хамрагдлаа. "Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор 19 дэх жилдээ зохион байгуулж буй “Монгол улсын иргэний андгай өргөх ёслол”-ыг Дундговь аймагт зохион байгуулж, Ерөнхий боловсролын 5 сургууль болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 16 нас хүрсэн сурагчдын төлөөллүүд оролцон иргэний үнэмлэхээ гардан авлаа." Тус онд 2 үйл ажиллагааг зохион байгууллаа. 2022 онд "Эх оронч залуу", Иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагаа, -“Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” дэд хэлэлцүүлэг нийт 3 үйл ажиллагааг залуучуудыг хариуцлагатай иргэн болгоход нөлөөлөх ажлын хүрээнд зохион байгууллаа.<br>2023 онд Залуучуудыг иргэний үүрэг хариуцлагаа ухамсарласан, эх оронч үзэлтэй иргэн болоход нөлөөлөх чиглэлээр: ”Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлоохоод залуусын бүтээлч хамтын оролцоо” чуулган, Эх оронч залуу, Иргэнийн андгай өргөх ёслол, "ИРЭЭДҮЙН ЭЗЭД - 2023" аян, нийт 4 арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.<br>"2024 онд Хүүхэд, залуучуудад түүх соёл, өв уламжлал, монголын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нүүдэлчин ахуй амьдрал, зан үйл, уламжлалыг таниулах хүрээнд "Монгол бахархал хөтөлбөр", "Нэг байгууллага -Нэг сайн үйлс" аян, "Говийн өнгө-Говийн залуус" эвент арга хэмжээ, "Эх оронч залуу" аян нийт 4 үйл ажиллагааг зохион байгууллаа. | |
| 77 | 2.4.6. Иргэд, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлнэ. | 2.4.6.1. Ослыг тэглэе” тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх | 2023 - 2024 | 0 | ОНТ 17,1 | 1 | "Ослыг тэглэе тусгай арга хэмжээний хүрээнд дараах сургалт, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: - 15 сумын ХАБЭА-н салбар зөвлөл, Эрүүл мэндийн салбарын холбогдох 50 албан хаагч, мэргэжлийн эмч нарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төвийн сургагч багш нарын сургалтад хамруулж гэрчилгээжүүлсэн. - АС сургалтын төвөөс зохион байгуулсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ХАБЭА” сургалтад Сайнцагаан сумын төрийн болон орон нутгийн өмчит ААН, байгууллагуудын удирдлага, ХАБЭА-н зөвлөлийн гишүүд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бүртгэх түр комиссын гишүүд нийт 200 ажилтан, албан хаагч нарыг хамруууллаа. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хүрээнд 17 контент бэлтгэж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрүүл ахуйн салбар зөвлөлийн цахим хуудаст байршуулан 8000 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. Үр дүн: Сургалт зохион байгуулснаар байгууллагын удирдлагууд болон холбогдох албан хаагчдын Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний талаар ойлголт мэдлэг нэмэгдэх, цаашлаад байгууллагадаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй орон тооны бус байнгын комиссыг байгуулсан байна. " | |
| 78 | | 2.4.6.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | УТХО 15,7 ОНТ 2,3 | 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэгийг 15 сумын 18 эрүүл мэндийн төв, хувийн 2 эмнэлэг, боловсролын салбарын 1, 5 сумын 26 аж ахуй нэгж байгууллага нийт 47 байгууллагад зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэн зөрчлийг арилгаж ажилласан. | 100% / 70%Үзлэг зохион байгуулснаар ямар үр дүн гарсан бэ? Тайланг баримт нотолгоогоор дэмжих, үр дүнг гүйцэт тайлагнах. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.2.2-ыг үндэслэв. |
| 79 | 2.4.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлнэ | 2.4.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулган, спортын арга хэмжээ зохион байгуулах | 2022 - 2024 | 0 | ОНТ 45,0 | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 2 жил тутам чуулган, жил бүр спортын арга хэмжээг зохион байгуулсан. 2022 онд "Боломжийг бүгдэд", 2023 онд Хамтдаа хөгжье бүсийн чуулган, 2024 онд "Тэгш оролцоо-хүртээмжтэй орчин чуулганыг зохион байгуулж нийт 293 хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсон байна. Үр дүн: Чуулганаас гарсан саналыг орон нутгийн бодлого төлөвлөлтөд тусган үе шаттай арга хэмжээ авч байгаа бөгөөд эхний ээлжид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд бочигийн спортыг хөгжүүлэх зорилгоор ХБХХТ-д 6,0 сая төгрөгөөр бочигийн хивс, хараагүй иргэдийн дуут гэрлэн дохиог 9.6 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар бүрэн шийдвэрлээд байна. | 100% / 100% |
| 80 | | 2.4.7.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг шинээр барьж ашиглалтад оруулах | 2022 - 2024 | 0 | УТХО 5700,0 | 100 | Азийн хөгжлийн банкны 5.7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын гүйцэтгэгчээр "Хөх хайрхан трейд" ХХК ажиллаж 2022 оны 12 дугаар сард улсын комисс хүлээн авсан. 2023 оны 11 дүгээр сард албан ёсоор хээлтээ хийж 25 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. | 100% / 100% |
| 81 | 2.5.1. Соёл, | 2.5.1.1. Төв | 2021 - | 10 | ОНТ150.3 | 70 | Төв Халхын Дуулалт Жүжгийн | 0% / 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | урлагийн салбарын насжилт өндөртэй барилга байгууламжийн тоо 2020 онд 14 байгааг 2024 онд 64.2 хувиар бууруулна. | Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилгын ажлыг үргэлжлүүлэх | 2024 | | | | Театрын шинэ барилгын ажил дээр 2022 онд Соёлын яамнаас Санхүү хөрөнгө оруулалтын хяналтын инженерүүд болон аймгийн удирдлагууд, шүүхийн шинжээч, барилга хөгжлийн төвийн инженер, Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, гүйцэтгэгч компани Суурь ххк, Эв констракшин ххкомпаниудын удирдлага, төлөөллүүд оролцсон баг ажилласан. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар ажлын зураг төсвийг шинэчлэн боловсруулж магадлалаар баталгаажуулан хүлээн авсан. Зургийн төсвийн гүйцэтгэгч балданс ХХК-д орон нутгийн төсвөөс 150.3 сая төгрөг зарцуулсан. Барилгын нийт төсөвт өртөг 33,406,869,944 төгрөг. | |
| 82 | | 2.5.1.2. Аймгийн Музейн барилгын зураг төсвийг хийлгэх | 2024 | 0 | | 100 | Соёлын тухай хуулийн дагуу шаардлагатай баримт бичгийн бүрдлийг бүрдүүлж холбогдох газарт хүргүүлэн. Барилгын зураг төсвийн 730.9 сая төгрөгийн төслийн саналыг 2025 оны улсын төсөвт суулгахаар Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд хүргүүллээ. Талбайн инженер геологийн судалгааны дүгнэлт хийгдсэн. | 0% / 0% |
| 83 | | 2.5.1.3. Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн | 2021 - 2024 | 0 | УТХО 7738,7 | 100 | Өлзийт сумын Соёлын төвийн барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.2 тэр бум төгрөгөөр баригдаж 2021 онд ашиглалтад | 50% / 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 136 | | 3.4.1.2. Жуулчдын голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий Дэл уул зэрэг газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах | 2021 - 2024 | 1 | УТХО 237,2 | 1 | 2021 оны тус аймгийн Өлзийт сумын Дэл уулын Хадан зургийн галлерейд, 2022 онд Гурвансайхан сумын Их газрын чулуунд, 2023 онд Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газарт “Отоглох цэг” байгуулж, нийт 3 отоглох цэгийг байгуулсан. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын “Отоглох цэг”-ийг Саруул сүмбэр нөхөрлөлд, Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын “Отоглох цэг”-ийг Дэл-Уулын гайхамшиг ТББ-д хариуцуулж, гэрээ байгуулсан. Отоглох цэг байгуулагдсанаас хойш нийт 1048 машин 2535 дотоод, гадаадын жуулчдад үйлчилсэн. | 100% / 100% |
| 137 | | 3.4.1.3. Сүм хөх бүрд зэрэг аялал жуулчлалын гол бүс нутгуудад орон нутгийн өмчийн болон | 2021 - 2024 | | УТХО 999,2 хандив 160,0 | 1 | БОАЖЯамнаас “Ижий говь” төслийн хүрээнд Сүм хөх бүрдэд 2 цомцог гэр, шилэн нүүр бүхий 150 хүний багтаамжтай асар, гэрэлтүүлэг, зөөврийн шилэн тайз зэрэг хөрөнгө оруулалтыг | 100% / 50%Зорилтот түвшинд хүрээгүй. 2022 оны хэрэгжилтийг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих замаар үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлнэ. | | | | | нийлүүлснээр 8 ор хоног нэмэгдэж хүчин чадал, үйлчилгээний чанарын стандарт сайжирсан. | хуулж тайлагнасан. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.2.3-ыг үндэслэв. |
| 138 | | 3.4.1.4. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, /хятад, солонгос, англи гэх зэрэг хэл дээр видео контентууд хийж/ орон нутгаа сурталчлах | 2021 - 2024 | 100 | ОНТ 11,4 Хандив 12,4 | 410 | ITM олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгийн дэмжлэгээр Говийн шуранхай АЖхолбооны зохион байгуулалтаар жил бүр 10-аас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага нэгдсэн зохион байгуулалттай оролцож, тур оператор компаниудтай жуулчин хүлээн авах гэрээ байгуулж, тараах материал, англи хэл, солонгос хэлээр байгалийн үзэсгэлэнт газрын видео контент, газрын зураг тарааж, орон нутгаа сурталчлан ажилласан. Ай Ти Эм аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсоны үр дүнд 2023 онд 634 гэрээ байгуулж, 30000 гадаад жуулчин хүлээн авах нөхцөл бүрдсэн. | 100% / 70%2024 оны гүйцэтгэл тайлагнаагүй. Тайлагналт хангалтгүй тул үнэлгээг бууруулж тооцов. |
| 139 | | 3.4.1.5. Нутгийн | 2021 - | | Хандив 55,0 | 4 | Нутгийн иргэдийг аялал жуулчлалд | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах | 2024 | | | | холбох, морин аялал зохион байгуулахад аргазүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс тус аймгийн малчин иргэдэд зориулсан сургалтад 31 иргэн хамрагдсан. Жуулчны баазуудын хөтөлбөрт үйл ажиллагаа Үндэсний дээл, хувцасны шоу, Айраг найргийн үдэш, Адууны өв соёлын баяр, Шөнийн музей, Морьтой Монгол аялал, “Spirit of gobi”, Боржигон найр зэрэг хөтөлбөрт 14 өв соёлын арга хэмжээг зохион байгуулж 1894 гадаад, дотоодын жуулчид оролцсон. | |
| 140 | | 3.4.1.6. Жуулчдад шаардлагатай мэдээллээр хангах мэдээллийн төвийг байгуулах | 2022 - 2024 | | ОНТ 76,5 хандив 13,0 | 400 | "Аялал жуулчлалын мэдээллийн төвийг 2022 онд Дундговьд үйлдвэрлэв дэлгүүрийн баруун талд тэрэг хэлбэртэй модон шалтай Цомцог гэрийг байрлуулсан. Мэдээллийн төвийг байнгын үйл ажиллагаатай болгохын тулд кофе шоп, түргэн хоол зэрэг үйлчилгээг давхар явуулах иргэнтэй гэрээ байгуулан ажиллуулж 2598 гадаад, дотоодын жуулчдад үйлчилгээ үзүүлсэн. Айхотел ХХК-тай гэрээ байгуулж “Дундговь” аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплекейшн, платформыг хийлгэсэн. " | 100% / 100% |
| 141 | | 3.4.1.7. Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг | 2021 - 2024 | | ОНТ 31,5 | 160 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам,“Хорека софт”, “Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв” ТББ, Аялал жуулчлалын хөгжлийн төв, | 100% / 100%Үр дүнг бүрэн тайлагнах, тайланг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | салбарын ажилтнууд болон иргэдийг хамруулж боловсон хүчнийг бэлтгэх | | | | | Монголын аялал жуулчлалын холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран аймгийн аялал жуулчлалын эрхлэгчид болон тэдгээрийн ажилчдад цахимаар болон танхимаар нийт 16 удаагийн сургалтад 482 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан. | баримт нотолгоогоор дэмжих, файл хавсаргах. |
| 142 | | 3.4.1.8. Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн дундаж үнэлгээг 90 хувьд хүргэх | 2021 - 2024 | 80 | | 90 | Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Дэлгэрцогт сумын 1-р багт байрлалтай Төв тулга чандмана ХХК-ийн "Говийн шинэ хүрхрээ" жуулчны бааз, Сайхан-Овоо сумын 1-р багт байрлалтай Дундговь ХХК-ийн "Сайхан говь" жуулчны бааз, Сайнцагаан сумын 9-р багт байрлалтай Ачлал оргил ХХК-ийн Ачлал оргил амралтын газрууд Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартаар 89-90% тохирлын үнэлгээтэй баталгаажуулалтанд хамрагдан тохирлын гэрчилгээтэй ажиллаж байна. | 70% / 70% |
| 143 | | 3.4.1.9. Аялал жуулчлалын бүс нутгуудад менежментийг сайжруулах | 2022 | | УТХО 269,0 | | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 сарын 13-ны өдрийн 24 дугаар тогтоолоор “Дэл уулын соёлын өвийн менежмент”-ийн төлөвлөгөө батлагдсан. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын Цагаан суварга, Дэл уулын бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх ерөнхий | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөгөөг “Нарт дизайн” ХХК-аар хийж гүйцэтгүүлэн аймгийн ИТХ-ын ээлжит 15 дугаар хуралдаанаар хэлэлцэн батлагдсан. Их газрын чулуу байгалийн цогцолбор газрын менежментийн төлөвлөгөөг хамгаалалтын захиргаанаас хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд нийт 3 газарт менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. | |
| 144 | | 3.4.1.10. Өлзийт, Гурвансайхан сумдад аялал жуулчлалын цогцолбор байгуулах | 2021 - 2023 | | УТХО 2160,0 Хандив хувийн хэвшил 1000,0 | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын Цагаан суварга, Дэл уулын бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг “Нарт дизайн” ХХК-аар хийж гүйцэтгүүлэн аймгийн ИТХ-ын ээлжит 15 дугаар хуралдаанаар хэлэлцэн батлагдсан. Эдийн засаг хөгжлийн яамны захиалгаар Цагаан суваргат Палентелогийн нөөцөд тулгуурласан “Аялал - судалгаа - амралт”-ын цогцолбор байгуулах ТЭЗҮ, зураг төсөв хийх ажлыг “Ланд Овнер” ХХК-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бага газрын чулууны аялал жуулчлалын бүсийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг Стийл проект ХХК-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. | 70% / 70% |
| 145 | 3.5.1. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн цахилгаан станцуудыг | 3.5.1.1. Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100 хувь шинэчилж, ашиглалтад | 2021 - 2022 | 80 | Төсөл хөтөлбөр 5800,0 | | Дэлхийн банкны санхүүжилттэй "Эрчим хүчний төсөл - 2" ажлын хүрээнд БЗӨБЦТС ТӨХК-ийн харьяа Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбарын 6, 0.4кВ-ын хүчдэлийн түгээх сүлжээг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дэд бүтэц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр хангана. | оруулах | | | | | шинэчлэх, цахилгаан хангамжийг сайжруулах ажил"-ын гүйцэтгэгч байгууллага болох “Проект ватт” ХХК нь нийт 5,8 тэрбум төгрөгөөр аймгийн төвийн 6кВ-ын 18км ЦДАШ, 6,3км КШ, 0.4кВ-ын 52км СИП шугам бүхий ЦДАШ, 3км КШ, ахуйн хэрэглэгчдийн 5800ш, ҮААН-ийн 400 хэрэглэгчийн тоолуурыг Ухаалаг тоолуураар солих ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. | |
| 146 | | 3.5.1.2. Аймгийн төвийн дулааны станцын ажлыг эхлүүлэх | 2021 - 2024 | | Гадаадын хөрөнгө оруулалт 5000 ам доллар буюу 17000,0 | 80 | Дундговь аймгийн төвд шинээр баригдаж байгаа дулааны станцын ажлыг 2023 оны 4 дүгээр сарын 15 -аас эхлүүлэн зуухны суурийн цутгалт 100%, зуух 1, 2-ын угсралт 80%, нүүрс хүлээн авах конвейрын суурийн цутгалт 40%, утаа сорогч, конвейрын барилгын суурийн ажил 20%-тай хийгдэж, нийт ажлын гүйцэтгэл 36 хувьтай байна. | 50% / 45%"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-ийг үндэслэв. |
| 147 | | 3.5.1.3. Аймгийн төвийн 2-р хэлхээний шугам сүлжээний ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2022 | | УТХО 730,0 | | 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 32,893,422,519 төгрөг батлагдсан. 2024 оны улсын төсөвт дулааны станцын цахилгааны ажлын 730,809,284 төгрөг сууж, ажил гүйцэтгэгчийг шалгаруулан, гэрээ байгуулаад ажлын гүйцэтгэл 50%-тай байна. | 50% / 50% |
| 148 | | 3.5.1.4. Эрчим хүч хэмнэх арга | 2021 - 2024 | 2 | ОНТ 2623,1 | 1 | "Аймгийн төвийн 6, 7, 8 байрны гадна фасад, тохижилт, дээврийн | 100% / 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын хөрөнгийг шийдвэрлэх | | | | | зураг, төсөв боловсруулан ажлыг “Скеч” ХХК-тай 15 сая төгрөгийн гэрээ байгуулан 2021 оны 7 дугаар сард хүлээлгэн өгсөн. Мөн 18 дугаар байрны гадна фасадын засварын ажлыг “Хүрэнжинсний-Овоо” ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 139,030,033 төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан. 2022 оны орон нутгийн төсөвт 4 төсөл арга хэмжээнд 353 сая төгрөг баталсан. Үүнд: - Биеийн тамир спортын газрын барилгын дээврийн засварын ажлыг Мандал Өргөө Голомт ХХК-тай 135,418,820 төгрөгийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. - ТХДЖТеатрын барилгын пасадны засвар ажлыг Хангда ХХК-тай 39,997,746 төгрөгийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. - “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн дээврийн засвар ажлыг Мандал шилтгээн ХХК-тай 148,134,854 төгрөгийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. - Аймгийн Засаг даргын тамгын газрын гадна фасад, дээврийн засварын зураг, төсөв боловсруулах ажлыг Люкс Товер ХХК-тай 12,230,000 төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан. 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын 12 айлын 15-р байрны пасадны засварын төсвийг баталж, ажлыг 100 хувь гүйцэтгэсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дундговь Энержи ХХК нь Дундговь аймгийн Сайнцагаан суманд 20 мВт-ын Нарны цахилгаан станц байгуулахаар Дундговь аймгийн Засаг даргатай, Энержи ХХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Мөнхболор нар хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт нарны станц барих газрыг шийдвэрлэж өгсөн. 2024 оны орон нутгийн хөгжлийн сангаас 2.013.224.798 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дундговь аймагт 4 байрны дээвэр 8 барилгын гадна пасадны засварын ажлыг хийж дуусган барилгын дулаан алдагдлыг бууруулсан." | |
| 149 | | 3.5.1.5. Аймгийн төвд шинээр баригдах дулааны станцын цахилгааны эх үүсвэр холбох 220/110/35кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажлыг ашиглалтад оруулах | 2021 | 10 | УТХО 410,0 | | Эрчим хүчний яам "Гэгээн цайтан" ХХК-тай 410,105,600 төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан. Аймгийн төвийн 220/110/35 кВ-ын Мандал дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил 100 хувь хийгдсэн. | 100% / 100% |
| 150 | | 3.5.1.6.. Аймгийн төвийн шинэ суурьшлын бүс болон шаардлагатай сумдын төвийн цахилгааны хангамжийг | 2021 - 2022 | 0 | ОНТ 491,8 | | "Луус сумын төвийн 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөлийн ажлыг “Цацрах хангай” ХХК-тай 69,121,267 төгрөгийн гэрээ байгуулан 2021 оны 9-р сард хүлээлгэн өгсөн.Сайнцагаан сумын Далай хорооллын 0.4кВ-ын | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайжруулах ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | | | | | цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг “Спэйшлтим ап” ХХК-тай 229.7 сая төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан. Хулд сумын 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг БЗӨБ ЦТС ТӨХК-ийн Дундговь цахилгаан түгээх сүлжээ ХХК гүйцэтгэсэн. Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн 0.4кВ-ын шугам, дэд станцын барилга угсралтын ажил /Сайнцагаан сум, Айраг баг/” 193,000,000 төгрөгөөр хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна. " | |
| 151 | 3.6. Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 2019 онд 5328.6 сая төгрөг байгааг 2024 онд 5386.1 сая төгрөгт хүргэнэ. | 3.6.1.1. Аймгийн төвд ачаа буулгах, хадгалах, шилжүүлэн ачих томоохон терминал логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах | 2023 | 0 | | | ТЭЗҮ боловсруулагдаагүй | 0% / 0% |
| 152 | | 3.6.1.2. Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замын ажилд анхаарч хамтран ажиллах | 2021 - 2024 | 0 | | 1 | Зам, тээврийн хөгжлийн яаманд хэвтээ ба босоо авто замын ойролцоо олон улсын тээвэр логистикийн төвийг байгуулах төслийн саналыг хүргүүлж, Ерөнхий сайдыг Дундговь аймагт ажиллах үеэр хэвтээ тэнхлэгийн авто замын асуудлыг эхлүүлэхээр санал тавьснаар Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн авто зам Чойр-Мандалговь чиглэлээс 2024 оны УТХО-д 17 тэрбум төгрөг батлагдсан. | 50% / 30%"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нийтлэг журам"-ын 6.2.2.4-ийг үндэслэв. |
| 153 | | 3.6.1.3. Мандалговь-Улаанбаатар чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу үүрэн телфоны сүлжээ бий болгох. | 2022 | | | 2 | Тус аймгийн улсын чанартай авто зам дагуух Дэлгэрцогт, Луус, Хулд, Өлзийт, Дэрэн сумдад үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлж, ашиглаж байна.. | 100% / 100%Шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшинг бүрэн тайлагнах |
| 154 | | 3.6.1.4. Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд хяналт тавьж, орон нутгийн авто замын засвар, арчилгааны хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2021 - 2024 | 1 | УТХО 16444,1 | 1 | 2021 оны улсын төсвийн хөрөнгөөр аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 2,8 км /Дундговь, Сайнцагаан сум/ ажил 100 хувь гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 2022 оны замын сангийн 496.6 сая төгрөгийн санхүүжилтээр Номгоноос Өлзийт мандал хүртэлх авто зам, явган хүний замын засвар, гэрэлтүүлэг, далан шуудууны тохижилтын ажлыг “Баянцогт зам” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авснаар аймгийн хэмжээний хатуу хучилттай авто зам 20.9 км болсон. 2023 оны замын сангийн 559,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын Номгон дэлгүүрийн урд замаас сургуулийн гудамж хүртэл зам талбайн тохижилтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд тус ажлын хүрээнд 0,3 км хатуу хучилттай авто зам, явган хүний замын ажлууд хийгдсэн. 2024 онд шинээр авто замын ажил | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийгдээгүй. А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 98 км, А0202 дугаартай Мандалговь-Даланзадгад чиглэлийн 154 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн их засвар арчлалтын ажлыг “Дундговь авто зам” ХХК шалгаран 2,883,879,285 төгрөгийн гэрээ байгуулан 2022 оны 5-р сарын 1-ний өдрөөс хөвөө, үерийн усны сувгийн шороог зайлуулах арчилгааны ажил, авто замын ан цав гагнах, нөхөөсний ажил хийгдсэн. 2023 онд Мандалговь-УБ чиглэлийн авто замын урсгал засварт Дундговь авто зам засварыг гүйцэтгэх 1050.0 сая, улсын төсвөөс 193-198 дах км замд бүрэн засвар хийгдэх 3.7 тэрбум, Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын урсгал засварт Дундговь авто зам засвар арчилгаа хийх 950.0 сая, улсын төсвөөс 14-19 дах км замд бүрэн засвар хийгдэх 3.4 тэрбум, 19-23 дах км замд бүрэн засвар хийгдэх 2.8 тэрбум төгрөг тус тус батлагдаж улсын комисс хүлээж авсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 604 сая төгрөгийн хөрөнгөөр Дундговь авто зам ХХК 19км авто замын засварын ажлыг хийсэн. | |
| 4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | |
| 155 | 4.1.1. Дижитал шилжилт хийх | 4.1.1.1. "Цахим аймаг- Ухаалаг Дундговь" цогц | 2021 - 2024 | 10 | ОНТ 2,8 | 95 | Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний газар болон хувийн хэвшлүүдтэй | 100% / 100%Тайлан өссөн дүнгээр |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг 2020 онд 10 хувьтай хэрэгжиж байгаа 2024 онд 80 хувьд хүргэнэ. | үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | | | | хамтран “Цахимд хэвшье” уриатай “Digital first D-1” үндэсний нээлттэй формыг зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, аж ахуйн нэгжийг цахим шилжилтийг хийх арга зүйн зөвлөмж, аймгийн удирдах албан хаагчдад цахим шилжилтийг хийх бодлогын зөвлөмж зэрэг сургалтуудыг зохион байгуулж цахим технологийн үзэсгэлэн худалдаа, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулж уг арга хэмжээнд давхардсан тоогоор 800 орчин иргэд, аж ахуйн нэгжүүд хамрагдлаа. Уг арга хэмжээний үеэр 300 гаруй иргэдэд цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулсан. 13 сумдын иргэд болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 23 агентлагуудын мэдээллийн ажилтангуудад цахим орчин дахь хүүхэд хамгааллын сургалтыг зохион байгуулсан. Нийт 15 удаагийн сургалтад 2500 орчим хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсан. | нэгтгэн, дүгнэж тайлагнах чиглэлд анхаарах |
| 156 | | 4.1.1.2. Сумдыг 4G сүлжээтэй болгох | 2022 - 2024 | 0 | Хувийн хэвшил-900.0 | 15 | 15 суманд 4G сүлжээтэй. Өлзийт сумын Буянт баг, Дэрэн сумын Саруул баг, Эрдэнэдалай сумын Рашаант багийг 4G сүлжээтэй болгосон. Сайхан-Овоо Төгрөг багийн Их овоо, Луус сумын Наран баг, Луус сумын Суварга багууд 4 G сүлжээг нэвтрүүлсэн. | 100% / 100%Тайланг 2021-2024 оны өссөн дүнгээр нэгтгэн, дүгнэж тайлагнах чиглэлд анхаарах. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Өмнөх оны тайлагналтаас муу тайлагнасан байна. |
| 157 | | 4.1.1.3. Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг улирал бүр зохион байгуулах | 2021 - 2024 | | ОНТ 14,0 | 7000 | Аймгийн Засаг даргаас сумдын удирдлагуудад “Иргэдээ сонсъё” арга хэмжээг 14 сумд 2 удаагийн уулзалт зохион байгуулж 1892, Говь-Угтаал, Хулд, Дэлгэрхангай, Дэлгэрцогт сумдын малчдын зөвлөгөөнд 1672 малчид, Сайнцагаан сумд иргэдийн уулзалтыг салбар бүрээр 5 удаагийн, нийт 33 удаагийн уулзалт зохион байгуулж 6600 иргэн хамрагдаж, уулзалтад оролцогчдоос 78 иргэн 150 гаруй санал хүсэлт ирснийг бодлогын баримт бичигт тусгаж төлөвлөх, газар дээр шийдвэрлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж нийт 10165 иргэд уулзалт арга хэмжээнд хамрагдсан. | 70% / 70% |
| 158 | | 4.1.1.4. Төрийн архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх | 2021 - 2024 | 90 | ОНТ 40,0 | 95 | "Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 1980-2016 оны нийт 3600 удирдлагын баримтыг цахим санд оруулсан. Төрийн архивын баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд 63 хөмрөгийн 78 дансны 4282 хадгаламжийн нэгжийн 554,526 хуудас баримтыг e-document.gov.mn буюу цахим санд оруулж цахимжууллаа. Төрийн архивд хадгалагдаж байгаа 109 хөмрөг үүсгэгч байгууллагаас 32 хөмрөг үүсгэгч байгууллагын 1942- | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2012 оны удирдлагын баримтаас нийт 1801 хадгаламжийн нэгж баримтыг 100% цахимд шилжүүлсэн. Нийт 1254 иргэний хүсэлтийг хүлээн авч 341 иргэнд лавлагаа, 913 иргэнд хувь хуулбар гарган өгч, нийт 1300 гаруй лавлагаа, хуулбар гаргаж үйлчилсэн. Эдгээр лавлагаанд давхардсан тоогоор 6630 гаруй хадгаламжийн нэгжийг мэдээлэл лавлагааны ажилд ашиглуулсан. | |
| 159 | | 4.1.1.5. Төрийн архивт нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | 50 | 43,9 ОНТ | 100 | Төрийн архивт хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж суурин компьютер, хурдны скайнер, олон үйлдэлт канноор хангаж, мөн төрийн архивын хадгаламжийн сангийн шалыг засаж, хяналтын камер, агааржуулалтын систем, хадгаламжийн сангийн гадна хаалганд ухаалга цоожийг суурилуулсан. Архивын тасгийн ажилчдыг ажиллах нөхцөл боломжоор хангах үүднээс хурдны скайннер, ширээний компьютер, баримт зөөх тэргэнцэр, А/3-ийн олон үйлдэлт канон, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс нягтруулсан 50 шүүгээг шийдвэрлэсэн байна. 43,990,0 ОНТ | 100% / 100% |
| 160 | | 4.1.1.6. Багийн Засаг дарга, малын эмч, байгаль хамгаалагч нарыг | 2024 | 10 | ОНТ 229,2 | 20 | 2023 онд 40 багийн Засаг дарга нарт, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын 7 байгаль хамгаалагчдыг унаажуулав. | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үе шаттайгаар унаажуулах | | | | | | |
| 161 | | 4.1.1.7. Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн ”Гэрэгэ ” систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг бүрэн арилгах | 2021 - 2024 | 8200 | | 2050 | "Аймгийн нэг цэгийн үйлчилгээний танхимд “Гэрэгэ” киоск машиныг суурилуулан ажиллуулж, уг киоск машинаар төрийн болон төрийн бус 55 байгууллагын 600 гаруй төрлийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжийг бүрдүүлж, төлбөр хураамжийг төвлөрүүлэн үйлчлүүлж байгаа нь төрийн үйлчилгээний шат дамжлага буурч иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл технологийн газраас мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 18-аас доош насны 8200 хүүхдийн бүртгэлийг аймгийн хэмжээнд гаргуулан авч зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулан 2050 хүүхдийн төрөлтийн бүртгэлийн зөрчлийг арилгахаар төлөвлөн бүртгэлийг мэдээллийн санд зөрчилгүй болгосон үр дүн гарсан. " | 100% / 100% |
| 162 | 4.2.1. Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 33.2 хувь байсныг 2024 онд 13.3 хувиар | 4.2.1.1. Төрийн албан хаагчдыг шатлан дэвшүүлэх зарчмыг баримтлах | 2021 - 2024 | | | 2 | Төрийн албаны тухай хууль болон чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцүүлэн 16 төрийн жинхэнэ албан хаагчийг шатлан дэвших зарчмын дагуу мэргэшсэн тогтвортой байдлыг ханган ажилласан нь нийт төрийн жинхэнэ албан хаагчийн 4.1 хувийг эзэлж байна. | 100% / 70%Тайлагналт хангалтгүй. Нийт хэдэн албан хаагч? Өмнөх оны тайланд 738 төрийн захиргааны албан хаагчаас 18 төрийн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | буурулна. | | | | | | | жинхэнэ албан хаагчийг шатлан дэвшүүлэн томилсон гэж тайлагнасан байна. Үр дүнг бүрэн тайлагнах, тайланг баримт нотолгоогоор дэмжих, файл хавсаргах. |
| 163 | | 4.2.1.2. Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах | 2021 - 2024 | 46 | | 230 | Удирдлагын академийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 20, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх давтан сургалтад 15, төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч тус тус улсын төсвийн санхүүжилтээр хамруулаад байна. Мөн Төрийн албаны сургууль Удирдлагын академтай хамтран сумдын багийн Засаг дарга нарыг чадваржуулах 2 өдрийн сургалтыг 2024.03.22,23-ны өдрүүдэд зохион байгуулж 68 багийн Засаг даргыг хамрууулсан. | 100% / 70%Тайлан хангалтгүй. Үр дүнг бүрэн тайлагнах, тайланг баримт нотолгоогоор дэмжих, файл хавсаргах. |
| 164 | | 4.2.1.3. Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад | 2021 - 2024 | | ОНТ 229,0 | 30 | 2021-2024 онд албан хаагчдыг мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр Засгийн газар болон төрийн байгууллагаас зохион байгуулсан нийт 512 | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суралцагчидтай гэрээ хийх | | | | | төрлийн сургалтад 2454 (давхардсан тоогоор) албан хаагчийг хамруулсан хамруулсан. үний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд орон нутгийн захиалгаар орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа ШУТИС, МУБИС, АШУИС, Глобал удирдагч их сургууль, Мандах бүртгэл дээд сургуульд суралцаж байгаа төгсөх курсийн 40 оюутантай гэрээ байгуулаад байна. | |
| 165 | | 4.2.1.4. "Нээлттэй-Дундговь" төсөл хэрэгжүүлэх | 2023 - 2024 | 0 | ОНТ 1075,0 | 100 | ээлттэй-Дундговь хөтөлбөрийн төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа болон ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, зөвлөх үйлчилгээний зардалд аймгийн төсөвт 200.0 сая төгрөг батлуулж төлөвлөгөөний орон нутагт ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсролын чанарыг дээшлүүлэх, шинээр ирж суурьших аж ахуйн нэгжийг дэмжин орон нутгийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, оюутан залуучуудад орон нутгийн хөгжлийн бодлого, сүүлийн жилүүдэд хийж хэрэгжүүлж буй бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийг танилцуулж санал бодол солилцох зорилгоор 6 дугаар сарын 7-9-ны өдрүүдэд УБ хот, Говь-Сүмбэр, Өмнөговь аймгуудад Дундговь аймгийн оюутан, залуучууд, иргэдэд зориулсан “Нээлттэй-Дундговь” чөлөөт уулзалтыг нийт 800 гаруй | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оюутан, залуучууд, иргэдийг хамруулан зохион байгуулсан. Мөн Говийн өнгө-Говийн залуус арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулж Говийн өнгө” үзэсгэлэн худалдаанд Дундговь, Өмнөговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай, Улаанбаатар хотын 200 гаруй бизнес эрхлэгч оролцож 1 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт, “Говийн залуус” 1000 залуучуудын зөвлөгөөнд 5 бүлгийн 828 залуус оролцож 69 төрлийн санал санаачилга гаргаж ирүүлсэн. Залуучуудын гаргасан саналыг эрэмбэлж нэгтгэн Говийн бүсийн залуусын “5 жилийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулж байна. Уг арга хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаас 195,956.4 төгрөгийг зарцуулсан. | |
| 166 | 4.2.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 4.2.2.1. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 80 | ОНТ 10,5 | 90 | "Төрийн албан хаагчдад шударга байдлыг төлөвшүүлэх зорилготой тус хугацаанд төрийн болон төрийн өмчит байгууллагын 1877 албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалтыг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар хэлэлцүүлэг зохион байгуулан, АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар 2 пэйж хуудсанд 6000 гаруй төрийн албан хаагчийг нэгдүүлэх арга хэмжээг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулав. ЭБАТ-уудын дунд уралдаан зарлан дүгнэж 7 сумын ИТХ, ЗДТГ-ын ЭБАТ-нуудыг урамшуулав. Тус өдрөөр иргэд, төрийн албан хаагчдад шударга байдлыг төлөвшүүлэх зорилготой соён гэгээрүүлэх сургалт, “Тик ток” уралдаан, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын дунд “АХА” “Центавр”, “Эрхээ мэдье”, “Авлигын эсрэг нэгдье” Үндэсний хэмжээний нөлөөллийн ажлыг олон нийтэд сурталчлах тэмцээн зохион байгуулсан. Төрийн албан хаагчдад шударга байдлыг төлөвшүүлэх зорилготой тус хугацаанд “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” аяныг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, Сайнцагаан сумын ЕБС, цэцэрлэгүүдээр аялуулж, соён гэгээрүүлэх сургалт сурталчилгаа, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчлах үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд иргэд, олон нийт, аймгийн иргэдийн Хурлын төлөөлөгч нараас ирүүлсэн саналыг тусган жил бүр боловсруулж, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдад хүргүүлэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт уг төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн семинар, сургалтыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулан ажилласан ба төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 93,2 хувьтай байна. 10.5 төгрөг-ОНТ" | |
| 167 | | 4.2.2.2. Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах | 2021 - 2024 | 80 | ОНТ 9,5 | 100 | Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад “Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, түүний онцлог”, “ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх, цахим системд баталгаажуулах тухай”, “ЭБАТ-ны үйл ажиллагаа, мэдүүлэг гаргагчийн хамрах хүрээ, ХАСХОМ-ийн тайлан мэдээ гаргахад анхаарах зарим асуудал”, “Мэдүүлгийн цахим систем ашиглалт” зэрэг сэдвүүдээр сум, байгууллагуудын салбар 49 ЭБАТ-уудыг анхан болон давтан сургаж чадавхжуулах сургалтыг цахим болон танхим хэлбэрээр зохион байгуулан ЭБАТ-нуудыг орон тоогоор тогтвор суурьшилтай ажиллуулж байна. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан сургалтуудад 15 сумын ЗДТГ, ИТХ, 128 байгууллагын 518 удирдлага, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч, нягтлан бодогч, Эрх бүхий албан тушаалтан, хэвлэл мэдээллийн ажилтан болон төрийн албан хаагчдыг оролцуулан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжоор тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлсэн үр дүн гарсан. 9.5 төгрөг-ОНТ | |
| 168 | 4.2.3. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд хүргэнэ. | 4.2.3.1. Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах | 2021 - 2024 | 2 | 10,2 ОНТ | 3 | Аймаг, сумдын “Эрх зүйн хөтөч”, “Насан туршийн боловсрол” зэрэг цахим хаягуудаар иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлж, Эрх зүйн хөтчүүдийг удирдлага зохион байгуулалтаар ханган “Иргэн бүрт эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр хүргэх 3 сарын аян”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж аймаг, сумдын Эрх зүйн хөтөчүүдээс бэлтгэн боловсруулсан цахим гарын авлага, брошур, кино, шторк, мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааг давхардсан тоогоор 238 удаа, 26504 хүнд хүргэж, цахимд 26637 удаагийн хандалт авч, бүх сумдад хүрч “ажилласан. Аймгийн ГХУСАЗСЗөвлөл, Тогтвортой амьжиргаа-3” төсөлтэй хамтран “Сум бүрт”, “Хууль тогтоомж сурталчлах өдөрлөг”, “Малчны хотод” зэрэг арга хэмжээнүүдийг хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. | 100% / 100% |
| 169 | | 4.2.3.2. Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг | 2021 - 2024 | 82 | | 89 | "Хуульчид нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйл ажиллагаа үзүүлэх зорилгоор аймгийн хууль хяналтын байгууллагууд хамтран “Хуульчийн | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх | | | | | про боно" өдөрлөгийн арга хэмжээг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулан 1310 гаруй хүн хамрагдаж, 557 хүнд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгч, хохирогч нарт өмгөөллийн үйлчилгээг улсын өмгөөлөгчийн зүгээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон прокурор, шүүхийн шатанд эрүүгийн 168 хэргийн 182, зөрчлийн 18 хэргийн 18, иргэний 15 хэргийн 15 нийт 201 хэргийн 215 үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалан өмгөөлөгчөөр оролцож үйлчилгээ үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 1141 иргэнд үзүүлсэн. Аймаг дахь ХЭҮК-ийн реферэнтэд ирүүлсэн 19 гомдол, мэдээллийг хүлээн авч 94,7 хувь шийдвэрлээд байна. | |
| 170 | | 4.2.3.3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг орон нутагт зохион байгуулах | 2021 - 2022 | 0 | ОНТ 0.5 Төсөл 8.5 | | Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт болон төсөвлөлт сургалтын 25 байгууллагын удирдлагууд, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга 15 нийт 40 албан хаагч, 200 төрийн албан хаагчийг хамруулж 10 бичил төслийг хэрэгжүүлсэн. | 100% / 100% |
| 171 | | 4.2.3.4. "Жендэрийн эрх тэгш байдал" тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 1 | ОНТ 9,9 Төсөл хөтөлбөр 10,0 | 1 | Тайлант хугацаанд жил бүр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, иргэд албан хаагчдын мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх аян арга хэмжээ зохион байгуулж 925 төрийн албан хаагч, 1909 иргэн хамрагдсан байна. Тухайлбал: 1. Эерэг өөрчлөлт-эмэгтэйчүүдийн | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцоо зөвлөгөөнийг эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал арга хэмжээг Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн Дундговь дахь салбартай хамтран зохион байгуулж, нийт 300 эмэгтэй, 216 эрэгтэйчүүдийг хамруулсан. 2. Жендэрийн үндэсний хороо, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Эрүүл нийгмийн төлөө эрчүүд” бичил төслийг хэрэгжүүлж 156 хөвгүүд, эрэгтэйчүүдийг сургалт, хэлэлцүүлэгт хамруулсан. 3. Харилцан хүндэтгэе аян арга хэмжээнд 1037 иргэн, 922 төрийн албан хаагчийг хамруулан жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. Нэг тэрбумаараа тэмцье эмэгтэйчүүдийн эрх чөлөөний алхалтад 200 гаруй төрийн албан хаагч, иргэд хамрагдан эмэгтэйчүүдийн эрхийн төлөө дуу хоолойгоо нэгтгэсэн юм. | |
| 172 | 4.3.1. Гэмт хэргийн гаралт 2018 онд 266 байсныг 2024 онд 10-аас доошгүй хувиар бууруулна. | 4.3.1.1. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого боловсруулан, хууль сахиулах байгууллагуудтай хамтран | 2021 - 2024 | 55 | ОНТ 5,5 | 45 | "Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар “Мэргэжилтний баг” байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлж, “Говийн хийморь” бүлгийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж, үйл ажиллагааг идэвхжүүлэхээр гишүүд, ахлагч нартай уулзалт ярилцлага зохион байгуулж, тус бүлгэмийн үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн арга хэмжээг зохион | 70% / 0%Шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй. Буурах атал эсрэгээрээ өссөн үр дүн гарсан байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх | | | | | байгуулж, нэгдсэн болон төрөлжсөн уулзалт ярилцлага, урлагийн тоглолт, театрчилсан тоглолт зэрэг үйл ажиллагааг явуулж, Улаанбаатар хот болон 14 аймгийн 40 гаруй бүлгийн 500 гаруй иргэд хүрэлцэн ирж оролцсон. “Архи үгүй амьдрал-Аз жаргал” аяныг “Та татгалз-Бид дэмжье”, “Та бол онцгой нэгэн” сэдэвт зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, “Говийн хийморь” АА бүлгийн ухаарлын яриа таниулга, “Хувь хүн өөрийгөө олох нь” сэдэвт хувь хүний хөгжлийн сургалтуудыг зохион байгуулсан. “Амьдрал сайхан” соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, Нэгдсэн эмнэлгийн дүрс оношлогоо, сүрьеэ, сэтгэц, дотрын эмчид тус тус үзүүлэн 3 төрлийн шинжилгээнд хамруулж, архинд донтох өвчтэй 13 иргэний дүгнэлтийг гаргуулсан. “Архигүй амьдралыг цогцлооё-Архигүй төрийн алба” аяны хүрээнд “Архи, согтууруулах ундааны нийгэм, гэр бүлд үзүүлэх хор нөлөө” сэдвээр сургалт мэдээлэл хийж, подкаст нэвтрүүлэг, 14 төрлийн зурагт хуудас, 4 төрлийн теле зохиомж бэлтгэн, иргэд олон нийтэд хүргэсэн. Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудад сургалт мэдээлэл хийж, хорт зуршлын хэрэглээнээс | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | татгалзах уриалга, хор холбогдлыг харуулсан 8 төрлийн зурагт хуудас, сэрэмжлүүгийг хувилж олшруулан иргэдэд сурталчилсан. 2024 оны 11 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 118 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 44 нэгжээр буюу 59.5 хувиар өсжээ. 5,5 сая төгрөг ОНТ | |
| 173 | | 4.3.1.2. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | 4 | 250,0 ОНТ | 14 | "Орон нутгийн хөгжлийн сангийн 250,0 сая төгрөгний төсөвт өртөг бүхий "Түр хамгаалах байр"-ыг 2024 онд ашиглалтад хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Цагдаагийн газар, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, Халамж үйлчилгээний газар, "Гэрэлтдэг ертөнц" ТББ, Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран "Хамгаалъя, хариуцлагатай байя", "Хайрлая, хүндэлье", "Нэг тэрбумаараар тэмцье", "Эрдмийн баяр", "Хамтарсан баг-Хамтын хүч" зэрэг 5 төрлийн тусгай арга хэмжээ, "Би хэн бэ?", "Өөрчлөлтийг өөрөөсөө", "Илрүүлье-Хамгаалъя", "Happy mum" зэрэг соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээнүүдийг тус тус зохион | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан. Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан 71 иргэнд хяналтын хувийн хэрэг нээж, нэг бүрчилсэн хяналт хэрэгжүүлж гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй 43 иргэнийг бичгээр баталгаа гаргуулан бүртгэлээс хасаж, энэ оны 9 дүгээр сарын байдлаар нийт 28 иргэнд хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нар хяналт тавин ажиллаж байна. Цагдаагийн газрын давхардсан тоогоор 91 алба хаагчдад “Аюулын зэргийн үнэлгээ хийх”, “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам”-аар сургалт зохион байгуулж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд хойшлуулшгүй ажиллагаа явуулах чадвар эзэмшүүлсэн. Энэ оны 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 42 бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг нуугдмал үед нь илрүүлж, таслан зогсоох, зөрчлийн шатанд нь хариуцлага тооцохыг зорьж ажиллаж байгаатай шууд холбоотой юм. | |
| 174 | | 4.3.1.3. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан | 2021 - 2024 | 16 | 457.9 ОНТ | 10 | "Зам тээврийн осол, хэргээс урьдчилан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учрах хохирлыг бууруулах, буруу дадал хэвшлийг арилгахад чиглэсэн “Аажуу явбал | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг үе шаттай зохион байгуулах | | | | | аяндаа хүрнэ дээ", "Уусан бол бүү жолоод", "Мотоцикл ба хамгаалах малгай", "Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл", "Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал", "Хүүхэд-Хөдөлгөөний аюулгүй байдал", "Нэг зам-Нэг соёл", "Хичээх өдөр", "Замын хөдөлгөөний цагаан толгой", "Мэдэгдэл", "Халтиргаа", "Цагийн менежмент", "Ургац" зэрэг нэгдсэн арга хэмжээ 12, "Гэрэл", "Хүн тээвэр", "Хөдөлгөөний аюулгүй байдал" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 20 удаа зохион байгуулсан. Цаг агаарын болон замын нөхцөл байдлын мэдээллийг өгч, мотоциклийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн подкаст, 2 төрлийн видео зохиомж, 13 төрлийн зурагт хуудас хийж байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулан, нийт 1.358.000 хэрэглэгчийн хандалт хийгдсэн байна. "Замын хөдөлгөөний цагаан толгой" арга хэмжээг жил бүр зохион байгуулсан. "Говийн ирээдүй" цогцолбор сургууль, "Цэгцбилэг" сургуулийн орчин дахь явган хүний гарцыг "Огторгуйн бүтээл" ХХК-аар хийлгэсэн. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 2 ерөнхий боловсролын сургуулийн орчинд явган хүний гэрлэн дохио суурилуулах ажлын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардагдах 54,273,800 төгрөгийн төсвийг шийдвэрлэж ашиглалтад оруулсан. Улсын төсвийн 403,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Улаанбаатар-Мандалговь чиглэлийн байнгын хяналтын пост, Дэлгэрцогт, Луус, Хулд сумдад хийгдэж буй “Дундаж хурдны камер”-ын тоног төхөөрөмжийг хүлээн авсан.Энэ оны эхний 11 сарын байдлаар зам тээврийн ослын 123 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс гэмт хэргийн шинжтэй 42, зөрчлийн шинжтэй 81 осол бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 10 нэгж буюу 19.2 хувиар буурсан байна. | |
| 175 | | 4.3.1.4. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачлага, оролцоотой томоохон гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | 32.7 | 2678,4 ОНТ | 45 | "Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 42 аж ахуй нэгж байгууллагатай хамтарч MNS6423:2019 стандартын шаардлага хангасан теле хяналтын камерын системийг суурилуулах ажлыг зохион байгуулах “Хамтран ажиллах гурвалсан гэрээ” байгуулан ажиллаж байна. Өлзийт сумын орон нутгийн хөгжлийн сангаас 37 сая төгрөг шийдвэрлэж, 360 градус эргэдэг, бичлэгээ 40 хоног хадгалах, -45-аас +45 хэмд хэвийн ажиллах хүчин чадал бүхий 4 теле камер, мөн тус бүртээ 4 ш гэрэл бүхий 8 цамхагт гэрэлтүүлэг байршуулан ашиглаж байна. | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн Засаг даргын 2023.04.25-ны өдрийн “Камержуулах ажлыг зохион байгуулах тухай А/259 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд 2 удаагийн нэгдсэн шалгалт зохион байгуулсан. Цагдаагийн газраас камержуулалтын талаар хийж хэрэгжүүлж буй ажлын явц байдал, үр дүнгийн талаар видео контент хийж газрын пэйж хуудсанд байршуулж олон нийтэд түгээн сурталчлах ажлыг зохион байгуулсан. Мөн камержуулалтын талаар энэ оны 9 дүгээр сард 3 удаа хяналт шалгалт хийж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 430 төрийн болон аж ахуйн нэгжийн гадна талын 534 хяналтын камер, 163 анхааруулах тэмдгийг “Camera.police.gov” санд шивж оруулаад байна. “Телекамерын хяналтын Дэд төв байгуулах” ажлын зураг төсвийг 53.916.726 төгрөгний төсвөөр гүйцэтгүүлж, их засварын ажилд 824.575.600 төгрөгний төсөв батлуулж, гүйцэтгэгч шалгаруулах тендэр зарлагдаад байна. “Аймгийн төвийн нэгдсэн камержуулалт”-ыг орон нутгийн хөгжлийн сангийн 1,8 тэрбум төгрөгөөр баталж тендэр шалгаруулалтыг зарлан “Бодь-Электроникс” ХХК-ний тендэрийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон. Энэ оны 11 сарын байдлаар иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 25 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 нэгж буюу 37.5 хувиар ээр буурсан ба энэ төрлийн хэргийн илрүүлэлт 65.5 хувьтай байна. | |
| 176 | | 4.3.1.5. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах | 2021 - 2024 | 29 | ОНТ 3,7 | 22 | "Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын “Малчдын зөвлөгөөн” зохион байгуулан Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах талаар шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудаар яриа таниулга хийж нийт 4150 малчин иргэд, төрийн алба хаагчдыг хамруулсан. Мөн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сонор сэрэмж, хариуцлагаа дээшлүүлэх, цахим гарал үүслийн гэрчилгээг харьяа мал эмнэлгийн нэгжээс хэрхэн авах талаар сургалт зохион байгуулсан ба энэ чиглэлээр 4 төрлийн видео шторк, 4 төрлийн зурагт постер сэрэмжлүүлэг хийж, аймгийн олон дагагчтай цахим хуудсанд байршуулсан. Аймгийн Мал эмнэлгийн алба хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцон “Мал эмнэлгийн гарал үүсэл, ариун цэврийн гэрчилгээнд хяналт тавихад анхаарах асуудал” сэдвээр | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалт зохион байгуулсан. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, оролцоо хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Мал-Мах” нэгдсэн арга хэмжээг жил бүр зохион байгуулж, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор байнгын болон хөдөлгөөнт пост ажиллуулах, мал бүхий иргэдэд “Малаа хариуцъя”, “Хулгайч нарт боломж бүү олго” уриалга бүхий 3000 гаруй боршур тараах материал хэвлүүлсэн. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 суманд нийт 14 малчдын бүлгийг шинээр бий болгож, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэ оны 11 сарын байдлаар мал хулгайлах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 буюу 50 хувиар буурсан ба хэргийн илрүүлэлт 100 хувьтай байна. " | |
